

ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2022 оны 11 сарын 04-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 10 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 5 дугаар хурал 10-р сарын 03-ны өдөр, Зөвлөлийн ээлжит бус 2-р хурал 10-р сарын 07-ний өдөр, аймгийн ИТХ-ын 12 дугаар Хуралдаан 10-р сарын 10-ны өдөр тус тус хуралдлаа.

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 5 дугаар хуралдаанаар аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төслийн тухай асуудлыг хэлэлцэж Хурлын хороодод шилжүүлэв. 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтыг батлах санал уламжлах тухай, Аймгийн зарим газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай, Зуунмод, Сэргэлэн сумдын хилийн цэсийн талаар санал уламжлах тухай, Газрын тосны хайгуулын талбайн дүгнэлт гаргуулах тухай асуудлуудыг хэлэлцэн Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

Сэргэлэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай асуудлын боловсруулалтын түвшинг сайжруулахаар төсөл өргөн баригчид буцаав.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг сум, орон нутгийн хамгаалалтад авах тухай асуудлыг хэлэлцэн Хурлын Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хороонд шилжүүллээ.

Аймгийн ИТХ-ын шагналын журамд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн Хурлын Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хороонд шилжүүллээ.

Мөн Нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх Хүндэтгэлийн хуралдааны тов тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын даргын захирамжаар батлав.

Хуралдааны тов тогтоож хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын 12 дүгээр Хуралдааныг 10-р сарын 10-нд хуралдуулахаар тогтгов.

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн ээлжит бус 2-дугаар Хуралдаанаар аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн аймгийн ИТХ-ын шагналаар шагнуулах тухай асуудлыг хэлэлцэж Хурлын Хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов.

Аймгийн ИТХ-ын XII Хуралдаанаар:

1. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулан “Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө” боловсруулсан тухай аймгийн Засаг даргын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Хороодоос хийсэн дүгнэлт, Төлөөлөгчдөөс гарсан саналыг хэлэлцээд “Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-г хавсралтаар батлав.

Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, хөгжлийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон аймгийн 2023 оны төсөвт тусган батлуулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтыг татах, “Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

2. Аймгийн хэмжээнд 2023 онд иргэдэд өмчлүүлэх газрын тухай аймгийн Засаг даргын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн 27 сумын хэмжээнд 2023 онд газар өмчилж авах иргэдийн нийт тоог 6267, 2023 оны өмчлүүлэх газрын хэмжээг 1325.69 га-гаар батлав.

Аймгийн хэмжээнд 2023 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, хэмжээ, байршлыг хавсралтаар дэмжиж, Монгол Улсын Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэн, холбогдох материалыг Засгийн газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргад даалгав.

3. Зарим газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтад авах тухай аймгийн Засаг даргын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн тусгай хамгаалалтад авах Баянцагаан сум Сац уул орчмын 148661 га, Алтанбулаг сум Цагаан бургаст орчмын 69049.2 га, Бүрэн сум Шивээт тойром орчмын 74916.8 га, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцагаан сумдын Зараат орчмын 172124.6 га, Эрдэнэсант, Өндөрширээт, Баян-Өнжүүл, Алтанбулаг

сумдын Хоньтын уулс орчмын 260521.2 га, Баяндэлгэр сумын Галттайн хойд нуруу, Галттайн гол, Галттайн урд нуруу, Баруун бүрхийн даваа 29828.7 га, Хуцаа гол, Замын даваа, Ангын хар уул, Баатарын толгой овоо, Шинэ бүрхийн горхи орчмын 7120.9 га, Баянжаргалан сумын Авдар, Хөх овоо, Өлзийтийн овоо, Баян Эрхт овоо, Цагаан нуур орчмын 21892.2 га, нийт 8 байршлын 784114.6 га талбайн солбицолыг нэгдүгээр, зураглалыг хоёрдугаар хавсралтаар батлав.

Тус тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийн талаарх мэдээллийг Ашигт малтмалын газрын мэдээллийн санд бүртгүүлэх, хамгаалалтын дэглэм, ашиглах горимыг тогтоохыг аймгийн Засаг даргад даалгав.

4.Зуунмод, Сэргэлэн сумдын хилийн цэсийн талаар санал уламжлах тухай аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд тус асуудалд өмнөх хуралдаанаар томилогдсон ажлын хэсгийг үр дүнтэй ажиллуулж Зуунмод, Сэргэлэн сумдын удирдлагуудыг оролцуулан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-д дахин өргөн мэдүүлэхийг аймгийн Засаг дарга, ажлын хэсэгт даалган буцаав.

5.Сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт батлах тухай мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Нийгмийн бодлого, хүний хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд сумын хамгаалалтад байх Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлав.

Жагсаалтаар баталсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын бүрэн бүтэн байдлыг хамгаалж, хяналт тавих, тэдгээрийг сэргээн засварлахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган батлуулж хэрэгжилтийг хангах, сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг Газрын кадастрын мэдээллийн санд бүрэн бүртгэх, сумын хамгаалалтад байх шаардлагатай боловч жагсаалтаар батлагдаагүй түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг бүртгэн батлуулах ажлыг шуурхай зохион байгуулах, аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтыг сайжруулах талаар дараах арга хэмжээ авахыг аймгийн Засаг даргад даалгав.

6.Газрын тосны хайгуулын Цайдам XXVI талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлахтай холбогдуулан “Дүгнэлт гаргуулах тухай” Ашигт малтмал газрын тосны газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны 1/4716 дугаар албан бичиг, Алтанбулаг, Архуст, Баян, Баянжаргалан, Баяндэлгэр, Баянцагаан, Сэргэлэн, Эрдэнэ, Мөнгөнморьт сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг хэлэлцээд газрын тосны хайгуулын нээлттэй сонгон шалгаруулалт зарлах Цайдам XXVI талбай нь 9 сумын 398 худаг уст цэг, булгийн эх, нуур цөөрөм, 7 сумын малчдын 317 өвөлжөө хаваржаа, малын бэлчээрийн талбай, 2 сумын газар тариалангийн талбай, 2 сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газар, 9 сумын нутаг дахь 198 хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцаж байгаа тул хуралдаанд оролцсон нийт төлөөлөгчдийн 100 хувийн саналаар дэмжих боломжгүй гэж шийдвэрлэв.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан шийдвэрийг холбогдох байгууллагуудад уламжлахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

7. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэн батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын шагналын журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын даргын 2022 оны 10 дугаар захирамжаар аймгийн ИТХ-ын төлөөлөгч М.Энхбатаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус ажлын хэсэг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журмыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн зарим өөрчлөлтийг хийж Хурлын хуралдаанд танилцуулж хэлэлцүүлээ.

Төр, засгийн болон аймгийн ИТХ-аас батлан гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлж бодит үр дүнд хүргэх үйлсэд идэвх зүтгэл гарган, Төв аймгийн эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд онцгой үр бүтээлтэй ажиллаж, амжилт гаргасан иргэн, байгууллага, хамт олныг шалгаруулан шагнахаар тусгасан бөгөөд өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журам”-ыг батлав.

“Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журам” батлагдсантай холбогдуулж тус журмыг мөрдөж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Ажлын алба, аймгийн Засаг даргад даалган

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт тэмдэг”, “Хүндэт жуух” хэвлүүлэх холбогдох зардлыг жил жилийн төсөвт тусган, шагналын санд багтаан шийдвэрлэхийг Ажлын албанд үүрэг болголоо.

7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн ИТХ-ын 2017 оны 6 дугаар хуралдааны 03 тогтоолын дагуу Хөрөнгө шийдвэрлэх тухай өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд акталж устгах барилгыг нэгдүгээр, дуудлагын худалдаагаар худалдах, балансаас балансад шилжүүлэх, актлаж устгах тээврийн хэрэгслийг хоёрдугаар, акталж устгах машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг гуравдугаар хавсралтаар батлан дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, дуудлагын худалдаатай холбоотой гарсан зардлыг эд хөрөнгийн суурь үнэ дээр нэмж дуудах, төлбөрийг аймгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, акталж устгах барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад зохион байгуулан тогтоолын хэрэгжилтийг шуурхай хангаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

8. Монгол Улсад нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний түүхт 30 жилийн ойг тохиолдуулан аймгийн Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох сонгуульд иргэд, олон түмний итгэлийг хүлээн 5 удаа сонгогдож, төрийн албаны анхан шатнаас Улсын Их Хуралд сонгогдох хугацаанд нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөвшүүлэн бэхжүүлэхэд хүчин зүтгэл гарган, аймаг, орон нутгаа удирдаж, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарыг хөгжүүлэх зорилтыг оновчтой тодорхойлон, хөгжлийн бодлогын томоохон баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж, үйл ажиллагааны үр дүнгээрээ улсын хэмжээнд “Шилдэг аймаг”-аар шалгарсан амжилт үзүүлж, аймгийнхаа хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн, Төв аймгийн Баян-Өнжүүл сумын уугуул, Зуунмод сумын харьяат Жигжидийн Батжаргалыг Төв аймгийн “Хүндэт иргэн” цол хүртээхээр уламжилсныг хэлэлцэн шийдвэрлэв.

9. Монголын үндэсний соён гэгээрүүлэгч, шашин соёлын нэрт зүтгэлтэн, үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгч II Богдын нэрэмжит аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнуулах тухай Засаг даргын мэдээллийг хэлэлцээд Монгол Улсад нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний түүхт 30 жилийн ойг тохиолдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Сэргэлэн сумын Засаг даргаар тус тус ажиллахдаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх, хяналт тавих, нийгмийн салбарын бодлогын баримт бичгийг боловсруулах, Төв аймагт буддын шашин, соёлыг хөгжүүлэх, энэрэн нигүүлсэхүйн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж, Төв аймгийн Сэргэлэн сумын уугуул Цэдэвийн Мэндсайханыг шагнахаар шийдвэрлэв.

10. Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн сургалтын төвийн газрын байршил өөрчлөх тухай аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн тус асуудлыг аймгийн ИТХ-ын 12 дугаар Хуралдаанаар хаалттай хэлэлцлээ.

Аймгийн ИТХ-ын 12 дугаар Хуралдаанаар нийт 10 асуудал хэлэлцэж 9 тогтоол батлав. Тус хуралдаанаас батлагдсан тогтоолыг аймгийн ИТХ-ын Khural.mn сайт, аймгийн ЗДТГ-ын мэдээллийн самбар, Нэгдсэн үйлчилгээний төвийн мэдээллийн самбарт байршуулан нийтэд мэдээллээ.

Бусад ажлын хүрээнд:

Аймгийн ИТХ-ын даргаас аймгийн Засаг дарга, салбарын яамд болон холбогдох албан байгууллагад 31 бичиг гарган хүргүүлж ажилласан бөгөөд энэ сард аймгийн ИТХ-д иргэдээс болон бусад байгууллагаас гаргасан өргөдөл гомдол бүртгэгдээгүй байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ойн хүрээнд МУИС-ын 80 жилийн ойг тохиолдуулан ОУХНУС-тай хамтран 2022 оны 10-р сарын 20-ны өдөр зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд Төв аймгийн ИТХ хамтран зохион байгуулагчаар оролцож аймгийн ИТХ-ын дарга, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, Ажлын албаны бүрэлдэхүүн оролцлоо.

Аймгийн ИТХ-ын Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хорооноос Бүрэн, Өндөрширээт, Эрдэнэсант, Эрдэнэ, Баяндэлгэр, Архуст, Баян сумдын ИТХ, БИНХ-д зөвлөн туслах, мэргэжил арга зүйн, зөвлөгөөр өгөх, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 14 дүгээр “Журам, загвар батлах тухай” тогтоолын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, E Mongolia цахим системийн хэрэгжилт, үйлчилгээний талаар хяналт хийхээр 2 ажлын хэсэг ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын Хүний эрх, өргөдөл гомдлын хорооноос ИТХурлын даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн Цагдаагийн газар, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаа болон түр хамгаалах байртай танилцаж, хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалган, үйл ажиллагаатай нь танилцлаа.

Тус хорооны гишүүд ажиллах явцдаа түр хамгаалах байр нь батлагдсан төсөв байхгүй бөгөөд хүн байрласан тохиолдолд баталсан төсөвгүй тул Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхэд хамгааллын зардлаас ахуйн болон хоол хүнсний зардалд зарцуулдаг, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй тул тогтсон хүний нөөц, ажилтан албан хаагч байхгүй талаар холбогдох албаны хүмүүс мэдээллээ. Тус байр нь нэг хүнд ноогдох талбайн хэмжээ стандартад зааснаас 2-3 дахин бага, хамгаалах шаардлагатай иргэдийг 7 хүртэлх хоногт байрлуулж хонуулахаас өөр үйлчилгээ үзүүлдэггүй, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүлээн авах байр, өрөөний хүрэлцээ дутмаг зэрэг нөхцөл байдлууд нь MNS 6040:2019 “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”-ын стандартыг хангахгүй байгааг холбогдох удирдлагуудад уламжилж, асуудлыг шийдвэрлэх талаар анхаарч ажиллахаа илэрхийлсэн байна.

2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 08.30 цагаас төрийн албаны нөөц бүрдүүлэх Ерөнхий шалгалт орон даяар эхэлсэн бөгөөд Төв аймагт зохион байгуулж буй шалгалтын үйл ажиллагаатай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригт танилцлаа.

Энэ хүрээнд Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Засаг даргын орлогч Г.Сурмаа, аймгийн ЗДТГ-ын дарга, Салбар зөвлөлийн дарга М.Отгонбат болон шалгалтын салбар комиссын гишүүдтэй уулзалт хийж, орон нутагт төрийн алба, хүний нөөцийн чиглэлээр тулгамдаж буй асуудал, төрөөс баримталж буй бодлого чиглэлийн талаар санал солилцож ажиллалаа.

Дэлхийн багш нарын 28, Монголын багш нарын 56 дахь жилийн баярын өдрийг тохиолдуулан Төв аймгийн ЗДТГ, БШУГ-аас боловсролын салбарын шинэчлэлд аймгийн залуу багш нарын манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх, үүрэг оролцоог идэвхжүүлэх уриан дор багш нартаа хүндэтгэл үзүүлж, “шинэ зууны боловсрол-залуу үеийнхэн” хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд УИХ-ын гишүүн Н.Энхболд, УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, Засаг дарга Д.Мөнхбаатар тэргүүтэй аймаг, сумын удирдлагууд, гавьяат багш нар, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Политехник коллеж, МСҮТ-ийн эрдэмтэн багш нар оролцлоо.

Жил бүрийн 10-р сард “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” тохиодог бөгөөд энэ өдрийг аймаг 13 дахь жилдээ зохион байгуулав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, 2030 он хүртэл 20,0 сая мод тарин “Ногоон Төв аймаг” бий болгох зорилт тавин, иргэдэд мод тарих, ургуулах аргачлал зэргийг олон нийтэд сурталчлан ажиллаж байгаагаас аймгийн хэмжээнд 2022 оны 8 сарын байдлаар 4268 иргэн, 1126 аж ахуйн нэгж байгууллага 27,5 га талбайд 428 мянга 424 ширхэг мод тарьсан байна.

Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ-аас байгууллагын ахмадууддаа хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Монголын Улсын орчуулгын түүхэнд томоохон байр эзлэх их хөлгөн судар Ганжуур Данжуур нь эртний болон дундад зууны Энэтхэг Төвдийн их бага таван ухаан болох дуун, учир шалтгаан, дотоод, тэжээх, урлах ухаан зэрэг шашны болоод иргэний таван мянга орчим ном зохиолыг багтаасан аугаа их цомирлог бөгөөд Монгол Ганжуурыг дахин хэвлэж, түгээх ёслол 10-р сарын 12-ны өдөр Төв аймгийн Манзушир хутагтын Даш Чойнхорлин хийдэд боллоо.

Ганжуур залах ёслолд аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма нар болон төр шашны төлөөлөл, сүсэгтэн олон оролцсон бөгөөд Энэтхэг улсаас хансүр лам Лувсанжалцан, Чойнбол Содба Лхаранба лам, Энэтхэгийн олон улсын Бурханы шашинтнуудын холбооны төлөөлөгч Дебудатта нар лам нарын хамт хүрэлцэн ирж оролцлоо.

Монгол Улсын Сонгуулийн хороо, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Хариуцлагатай сонгогч” сургалтын хөтөлбөрийг 2022-2024 онд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Төв аймгийн “Хүмүүн” цогцолбор, IV, V сургуулийн ахлах ангийн сурагчид, политехникийн коллежийн оюутнуудад “Хариуцлагатай сонгогч” байх мэдлэг боловсролыг олгох сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтад хамрагдсанаар сонгуулийн ач холбогдол, сонгуулийн эрх болон үндсэн зарчмууд, үйл явц, мөрийн хөтөлбөр гэж юу болох, сонгуулийн сурталчилгааны хууль ёсны арга хэлбэрүүдийг хууль бус арга хэлбэрүүдээс ялгах, сонгуульд оролцогч талуудын үйл ажиллагаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хяналт тавьж хамтран ажиллах чадварт суралцах юм. Сургалтын сургагч багшаар аймгийн ИТХ-ын Хууль

эрх зүй, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга А.Батцэцэг, төсвийн ерөнхий нягтлан бодогч Б.Одончимэг ажиллаж, сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Ус хангамжийн эх үүсвэрийн аюулгүй байдалд эрсдлийн үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн томилох тухай” А/583 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэгт аймгийн ИТХ-ын Ажлын албаны ХЭЗХШҮ-ний хэлтсийн дарга ажиллалаа. Тус ажлын хэсэг 10 дугаар сарын 17-ны өдөр аймгийн төвийн худаг, ус, ундны усыг нөөц сангийн харуул хамгаалалт, нөхцөл байдлыг шалгаж санал, дүгнэлтээ ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлэн ажилласан байна. Тус ажлын хэсгийн дүгнэлт, саналыг нэгтгэн зөвлөмж боловсруулаад байна.

Аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн барилгын ажлын явцтай танилцлаа. Тус эрүүл мэндийн төвийн барилга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй зарлагдаж, гүйцэтгэгчээр “Арбулаг” компани шалгаран, ажлын явц 75 хувьтай байна. Тэрээр гүйцэтгэгч компаний удирдлагуудтай уулзаж, хүйтний улирал эхэлж байгаатай холбоотой эрчимтэй ажиллаж энэ оны 11-р сард багтаан бүрэн дуусгаж хүлээлгэн өгөх талаар санал солилцсон байна.

Мөн Баян сумын төв доторх 2 км авто замын ажлыг сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 455 сая төгрөгийн санхүүжилтаар эхлүүлж байгаа бөгөөд авто замын ажлын далан болон гүүр хоолойн ажлыг 2023 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүлээлгэн өгөхөөр төлөвлөн “Неон гэгээ” ХХК ажлаа эхлүүлсэн байна. Баян сумын сумын төвийн шав тавих ёслолд Төв аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, БЗОСК-ийн захирал Ж.Баттөгс, Баян сумын удирдлагууд, төрийн албан хаагчид, иргэдийн төлөөлөл оролцсон байна.

Монгол Улсад нутгийн өөрөө удирдах байгууллагын 30 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан сумдын ИТХ-ууд тус ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Лүн сумын ИТХ 10-р сарын 14-ний өдөр нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан байна. Энэ ажлын хүрээнд сумын үе үеийн Хурлын дарга нар, ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байсан ахмад депутатуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн байна.

Хүндэтгэлийн арга хэмжээнд Төв аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма оролцож сум орон нутгийн төлөөллийн байгууллагад олон удаа иргэдийнхээ итгэлийг олон удаа сонгогдож ажилласан сумын ахмад төлөөлөгчид, төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчийг аймгийн ИТХ-ын “Хүндэт тэмдэг”, “Хүндэт жуух”-аар шагнаж урамшууллаа.

Баян сумын ИТХ-ын ажлын алба болон Засаг даргын тамгын газраас 2022 оны 10-р сарын 21-ний өдөр нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч Ж.Баттөгс, Баян сумын ИТХ-ын дарга Л.Батсуурь, Засаг дарга М.Мөнх-Эрдэнэ, үе үеийн ИТХ-ын дарга нар болон Төлөөлөгчид оролцлоо.

Орон нутгийн 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхийнхээ хугацаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэдтэйгээ хамтран сум орон нутгийнхаа хөгжлийн төлөө, тулгарч байгаа асуудлыг үе шаттай шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд хүндэтгэлийн арга хэмжээний үеэр ахмад төлөөлөгчдийг аймгийн ИТХ-ын шагналаар шагналаа.

Аймгийн ИТХ-ын Ажлын алба, ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран Сэргэлэн сумын ИТХ-ын Төлөөлөгчид, төрийн албан хаагчдад авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар сургалт хийж ажиллалаа. Сургалтад тус сумын ИТХ-ын төлөөлөгч, төрийн албан хаагч нийт 27 хүн оролцож авлига, ашиг сонирхлын тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл авч, мэдлэгээ нэмэгдүүлсэн байна.

МУ-ын ЗГХЭГ, Швейцарын хөгжлийн агентлагийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцын чадавхыг бэхжүүлэх нь” төсөл, Төв аймгийн ИТХ-аас 10-р сарын 31-ний өдөр хамтран зохион байгуулах “Орон нутгийн бодлого төлөвлөлт ба үр дүнд суурилсан хяналтын тогтолцоо” бүсчилсэн сургалт хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг аймгийн ИТХ-ын Ажлын алба ханган ажиллаж байна.

Тус сургалт, хэлэлцүүлэгт Төв, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Дорнод аймгийн ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ИТХ-ын төлөөлөгчид, Хурлын хороодын дарга нар, Зөвлөлийн гишүүд оролцох юм.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хүрээнд:

Төв аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн II хуралдаан 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хуралдаж аймгийн ГХУСАЗЗ-ийн 2022 төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээлэл цаашид анхаарах асуудал, 2022 онд Төв аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын мэдээ, цаашид анхаарах асуудал, Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион явуулсан “Устгал” нэгдсэн арга хэмжээний тайлан гэсэн 4 асуудлыг хэлэлцэн холбогдох байгууллагад үүрэг чиглэл хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

10-р сарын 14-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд аймаг, нийслэл, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгууллаа

Тус сургалтаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тодорхой төрлийн гэмт хэргийг бууруулахад салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, салбар зөвлөлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах, эрх зүйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх талаар сургалт хийгдэж сургалтад 21 аймаг, нийслэл, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга, нарийн бичиг, мэргэжилтнүүд хамрагдсан байна.

Аймгийн ГХУСАЗСЗ, аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээс аймгийн хэмжээнд нөлөөллийн сургалт зохион байгууллаа.

Мөн “Архигүй үлгэрлэе” аян хүрээнд “Гэр бүлийн үнэ цэнэ” сургалтыг “Инээмсэглэж буй гэр бүл” ТББ-тай хамтран зохион байгуулж, Зуунмод сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 46 сурагч хамруулав.

Төв аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас гэмт хэрэг зөрчлийн нийгмийн хор аюулыг олон нийтэд таниулах ажлыг тасралтгүй явуулах, сумдын ГХУСАЗСЗөвлөл, “Хамтарсан баг”-ийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, салбар дундын зохицуулалтыг хангах, гишүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх, хохирогчид үзүүлдэг үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цаашдын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор баруун бүсийн сургалтыг Лүн суманд 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж нийт 64 албан хаагч хамрагдав.

Тус сургалтыг зохион байгуулснаар сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хамтарсан багийн ажлын уялдаа холбоо сайжирч, хамтарсан багийн гишүүдийг мэргэшүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх хамтын ажиллагааг сайжруулах, хамтарсан багийн ажиллах нөхцлийг сайжруулах, чанар хүртээмжийг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс эцэг эх асран хамгаалагч, жолооч нарт хандан Зам тээврийн ослол гэмтлээс хүүхдүүдээ хамгаалах уриалга гаргаж “Жолооч та хүүхэд хамгаалагч” замын тэмдэглэгээг ачаалал бүхий 4 цэгт байрлуулж, Хүмүүн цогцолбор бага сургуулийн авто зогсоолд хаалт байршуулах зэрэг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нийтийн албан тушаалтныг авлигын эсрэг соён гэгээрүүлэх, чадавхжуулах замаар авлигаас урьдчилан сэргийлэх сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Сэргэлэн суманд зохион байгууллаа.

Сургалтад Сэргэлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Төрийн албан хаагчид хамрагдаж авлигын эсрэг хууль, тогтоомжийн талаарх мэдлэг, чадвараа дээшлүүллээ.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

10-р сард Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааныг 1 удаа хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажилласан. Уг хуралдаанаар 12 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн барих 6 асуудлыг холбогдох бодлогын хэлтсүүдээс авч өргөн барьсан.

Мөнгөнморьт сумын засаг дарг М.Батчимэгийн ажил хүлээлцэх ажлын хэсгийг томилж, үүрэгт ажлыг хүлээлцэж үүрэг даалгавар өгсөн.

10-р сарын 24-27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Куанг Нинх мужид зохион байгуулагдсан Зүүн Азийн бүс нутгийн Аялал жуучлалын форум ЕАТОФ холбооны 17-р Ерөнхий чуулганд Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар болон бусад удирдлагууд, бизнес эрхлэгч нар оролцож “Бүс нутгийн Аялал жуучлал хэвийн эринд шилжих

нь” сэдэвт илтгэл тавьж бусад гишүүн мужуудын удирдлагуудтай аялал жуучлалын салбарт хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцов.

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 10 сарын 11, 24-ний өдрүүдэд танхимаар 2 удаа зохион байгуулж, тэмдэглэлээр 25 заалт бүхий үүргийг холбогдох байгууллага, суманд хүргүүлж, хэрэгжилт тооцов. Нэгдсэн шуурхайд өгөгдсөн үүргийг цахим үнэлгээний систем болох tov.unelgee.gov.mn-д оруулж, тайлагнаж эхэллээ.

Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар 2022 оны III улирлын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг танилцуулж, тэмдэглэлээр 6 заалт бүхий үүргийг холбогдох байгууллага, нэгж, сумдад хүргүүлэв. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02/1785 албан бичгээр хэлэтс, агентлаг, сумдын Засаг дарга нарт 5 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг даалгав. III улирлын мэдээг хүснэгтээр харуулбал:

2022 оны III улиралд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал /Өссөн дүнгээр/

№	Нэр	Нийт	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн ИТХ	29	19	8	0	2	93, 10
2	Аймгийн ЗДТГ	600	513	34	0	53	91,17
3	Сумд	10202	9520	109	109	464	95,45
4	Харьяа агентлаг, хэлтэс	1909	1774	37	8	90	95,29
Нэгдсэн дүн		12740	11826	188	117	609	95,22

2022 оны III улиралд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол хэлбэрээр /Өссөн дүнгээр/

№	Нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	Аймгийн ИТХ	29	29	0	0	0	0
2	Аймгийн ЗДТГ	600	275	190	60	75	0
3	Сумд	10202	9202	155	130	698	17
4	Харьяа агентлаг, хэлтэс	1909	1824	54	13	18	0
Нэгдсэн дүн		12740	11330	399	203	791	17

2022 оны III улиралд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол агуулгаар /Өссөн дүнгээр/

Төв аймаг	Нийт 12740 өргөдлөөс 1. Хүсэлт 12221/ 95.93% 2. Гомдол 374/ 2.94% 3. Санал 145/ 1.14% 1. Иргэний бүртгэлийн чиглэлээр 3219 /25.26% 2. Газартай холбоотой асуудлаар 2594 / 20.36% 3. Халамжийн үйлчилгээний чиглэлээр 2102/ 16.49% 4. Нийгмийн даатгалын чиглэлээр 732/ 5.74% 5. Ажил, тусламж хүссэн 728 / 5.71%
-----------	--

2023 онд тэгш ой тохиох сумдын иргэдийн санал хүсэлтийг цахимаар хүлээн авч нэгтгэн аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг хуралдуулж, салбар тус бүрийн чиглэлээр хэрхэн стратеги төлөвлөгөө боловсруулах талаар үүрэг чиглэл өгөв.


27 сумын ЗДТГ-ын дарга нарт “Нутгийн захиргааны байгууллагын удирдага зохицуулалт” сэдэвт 3 хоногийн цахим сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан.

Байгууллагын албан хаагчдад нэг сарын Монгол бичгийн сургалтыг зохион байгуулж эхэлсэн.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХҮРЭЭНД

Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:


Салбар зөвлөлийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд улирал тутам хяналт шинжилгээ хийж, үйл ажиллагааны мэдээг сар тутам гаргаж байна. 3 дугаар улирлын биелэлт 81.6 хувьтай байна.



Тайлант сард дараах судалгаа, мэдээллийг гарган хянаж, ТАЗ-д хүргүүлсэн байна.

- ✓ Хэлэлцэгдэх буй 3 журмын төсөлд тусгах санал.
- ✓ Төв аймгийн хэмжээнд 207 төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн судалгаа мэдээлэл.
- ✓ Сул орон тоо, түүний нөхөн хангалтад нөлөөлж буй шалтгаан
- ✓ 27 сум, 97 багийн бүтэц, ороны судалгаа

Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 78 тогтоол гаргасан бөгөөд дундажаар 97.00%-ийн биелэлттэй байна.



Салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдол, СЗ-өөс явуулсан хариутай бичгийн шийдвэрлэлтийг танилцуулбал:

№	Төрөл	Нийт тоо	Үүнээс хариутай	Шийдвэр -лэсэн	Хүлээг-дэж буй	Шийдвэр-лэлтийн хувь
1	Ирсэн албан бичиг	251	174	156	18	89.65%
2	Ирсэн өргөдөл, гомдол	14		14	0	100%
3	Явсан албан бичиг	144	130	127	3	97.69%

Сургалт, мэдээллийн чиглэлээр:

2022 оны 10 дугаар сарын байдлаар Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” арга зүйн дэмжлэг үзүүлэх цахим сургалт 27 удаа зохион байгуулагдаж, салбар зөвлөлийн гишүүд, холбогдох сум, агентлаг, байгууллагын албан хаагчид хамрагдсан.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс 2022 онд “Ёс зүйтэй төрийн алба, Бүтээмжтэй төрийн албан хаагч” уриа дэвшүүлэн ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд Улсын бүртгэлийн хэлтэс, Политехникийн коллежоос ирүүлсэн захиалгын дагуу “ТАны зүй-харилцаа” сэдэвт сургалтыг Төв аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга Г.Мөнхгэрэл хийж, цаг үеийн зарим мэдээллийг өглөө. Сургалтад 2 байгууллагын албан хаагч, багш, ажилтан хамрагдсан.



ёс

74



Төв HR клубын гишүүд Мерит төслийн техникийн зөвлөх Билл Гаутай өглөөний уулзалт хийж, хүний нөөцийн мэргэжилтний албан тушаалын үнэ цэнэ, цаг ашиглалтын зохицуулалт, дараалсан үүрэг даалгавруудаас чухлыг нь хэрхэн тодорхойлох арга барилын тухай мэдээлэл авч, ярилцлаа. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалт, шинэчлэл” богино хугацааны цахим сургалтад 8 албан хаагч хамрагдлаа.

Сонгон шалгаруулалтын чиглэлээр:



Төрийн албаны нөөц бүрдүүлэх Ерөнхий шалгалт 2022 оны 10 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.

Салбар зөвлөлийн 2022.10.04-ний өдрийн 76 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар төрийн албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг Төв аймагт




зохион байгуулах салбар комиссыг 5, дэд ажлын хэсгийг 8 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулав. Тус тогтоолын 2 дугаар хавсралтаар ерөнхий шалгалт зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг 21 ажил үйлчилгээтэйгээр батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангалаа.

Шалгалтын комисс, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Үйлчилгээний алба, хэвлэл мэдээллийн алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Тагнуулын хэлтэс, Цахилгаан болон Мэдээлэл сүлжээний холбооны газруудын төлөөлөл 13 ажилтан, албан хаагч үүрэг гүйцэтгэн ажиллав.

Шалгалтын үеэр Төв аймагт зохион байгуулж буй шалгалтын үйл ажиллагаатай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг танилцлаа. Энэ хүрээнд Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Засаг даргын орлогч Г.Сурмаа, аймгийн ЗДТГ-ын дарга, Салбар зөвлөлийн дарга М.Отгонбат болон шалгалтын салбар комиссын гишүүдтэй уулзалт хийж, орон нутагт төрийн алба, хүний нөөцийн чиглэлээр тулгамдаж буй асуудал, төрөөс баримталж буй бодлого чиглэлийн талаар санал солилцлоо. Мөн Ерөнхий шалгалт өгч буй иргэдэд мэдээлэл өгч амжилт хүслээ. Мөн Баянхангай, Баян-Өнжүүл, Угтаалцайдам сумын Засаг дарга нар Ерөнхий шалгалтын үйл ажиллагаатай танилцлаа.







ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН ЯВЦЫН МЭДЭЭ (ТӨВ АЙМАГ-2022.10.14-15)

Д/д	Огноо	Эхлэх цаг	Ирц				Ерөнхий мэдлэгийн шалгалт		Монгол хэл бичгийн шалгалт		Дүн шинжилгээ хийх чадварын шалгалт		Тэнцсэн иргэдийн хувь
			Ирвэл зохих	Ирсэн	Ирээгүй	Хувь	Тэнцсэн иргэдийн тоо	Хувь	Тэнцсэн иргэдийн тоо	Хувь	Тэнцсэн иргэдийн тоо	Хувь	
1	2022.10.14	8:30	26	22	4	84.61%	9	40.10%	5	22.72%	5	22.72%	22.72%
2		11:00	26	19	7	73.07%	4	21.05%	4	21.05%	4	21.05%	21.05%
3		14:00	26	22	4	84.61%	8	36.40%	5	22.72%	5	22.72%	22.72%
4		18:30	26	22	4	84.61%	8	36.40%	8	36.40%	8	36.40%	36.40%
5	2022.10.15	8:30	26	21	5	80.76%	12	57.14%	9	42.85%	8	38.09%	38.09%
6		11:00	22	17	5	77.27%	8	47.05%	6	35.29%	6	35.29%	35.29%
НИЙТ ТОО			152	123	29	80.92%	49	39.83%	37	30.08%	36	25.88%	29.26%

90-ээс дээш оноотой 5 иргэн, 80-89 оноотой 10 иргэн, 70-79 оноотой 17 иргэн, 65-69 оноотой 4 иргэн байна.



Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сул орон тооны нөхөн хангалтыг 2022 оны 10 дугаар сарын 20-ны байдлаар танилцуулбал:



Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөх тусгай шалгалтыг 10 дугаар сарын 31-нд, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг 11 дүгээр сарын 07-нд зохион байгуулахаар бэлтгэл хангалаа.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

2022 оны 10 дугаар сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт 15 байгууллага 500 гаруй төрлийн үйлчилгээг 6867 иргэнд, өдөрт дунджаар 300-350 иргэнд хүргэн үйлчилсэн байна.

Тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Цахим мэдээлэл солилцооны нэгдсэн систем /www.e-mongolia.mn/-ийг нэвтрүүлсэн бөгөөд тус системээр дамжуулан 10 сард аймгийн хэмжээнд 720 лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас 531 лавлагаа үйлчилгээ авчээ.

Харин Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд 9 гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан, одоогийн байдлаар шийдвэрлэх хугацаа болоогүй 5 гомдол байна.

Байгууллагын цахим мэдээллийн буланд байх ухаалаг дэлгэцүүдээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт 132 иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан 77 иргэн машины татвар, торгууль, улсын бүртгэлийн лавлагаа, жолоочын хариуцлагын даатгал, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авчээ.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Төв аймагтай хил залгаа Сэлэнгэ, Дундговь, Булган, Говьсүмбэр, Хэнтий аймагтай байгуулсан хамтран ажиллах төлөвлөгөөг тодотгосон. Эрдэнэ суманд байгуулах сайн дурын хэсгийн барилгын нээлтийн ажиллагааг зохион байгуулсан. Онцгой байдлын газрын ой, хээрийн түймэртэй тэмцэх шуурхай бүлгийн томилгоонд тодотгол хийсэн. Төв аймгийн гамшгаас хамгаалах дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд тодотгол хийсэн.

Онцгой байдлын газрын нөхөн хангалт, Офицер бүрэлдэхүүний нөхөн хангалт 78,7%-тай, ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалт 68,3% -тайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар офицер бүрэлдэхүүний түвшин тогтоох үзлэг, мэргэшлийн зэргийн шалгалт 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдаж Онцгой байдлын газраас 27 алба хаагч хамрагдсанаас / эрэгтэй-24, эмэгтэй-3/ мэргэшлийн зэргийн болзол хангасан.

Алба хаагчдыг гал түймэр, гамшиг ослын голомтод болон дасгал сургуулийн үед үүрэг гүйцэтгэхдээ аюулгүй байдлыг ханган, тактикийн алдаа дутагдал гаргуулахгүй байх зорилгоор “Гал түймэр унтраах дүрэм”, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”, “Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”-ээр давтан сургалт явуулж шүүлэг авсан.

Гал түймрийн болон гамшиг ослын дуудлагаар ажиллах салаа, бүлгийн холбоо мэдээллийн техник хэрэгсэлийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, мэдээ мэдээллийг цаг тухай бүрд дамжуулж, АТС гарсан 4 удаагийн гэмтэл, радио холбоонд гарсан гэмтэлийг цаг хугацаанд засварлаж ажиллаж байна.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Харилцаа холбоо зохицуулах газар, Юнител компани орон нутгийн салбар, Орон нутгийн телевиз TBS, телевиз FM 96.3 байгууллагуудтай холбогдох хууль тогтоомжын дагуу телефон утас хэрэглэгчийн гэрээ, техник үйлчилгээнд засвар хийх гэрээ, мэдээ мэдээлэл солилцох журам, харилцан ажиллах гэрээг байгуулан хамтран ажиллах гэрээний загварыг хэвлэж хүргүүлээд байна.

Онцгой байдлын ерөнхий газраас Зохион байгуулсан Эмч-Сэтгэл зүйч, Эрэн хайх аврах салбарын бүлгийн дарга нарын сургалтанд бүрэлдэхүүнийг бүрэн хамруулсан. Мөн эмч сэлгэл зүйчийн цахим сургалтанд сүлжээний доголдол гаргалгүй ажиллаа.

Онцгой байдлын газрын хэмжээнд ний хэрэглэгдэж буй хэт богино догионы радио станцын хэрэглэгчийн тоо 13 бэлэн байдлын богино хэт богино долгионы 12 радио станц Лүн сум дахь Эрэн хайх аврах бүлэгт 3 нийт 28 радио станц ашиглагдаж байна.

Мөн Онцгой байдлын газрын радио холбооны болон мэдээллийн техник хэрэгсэлийн ашиглалтыг сайжируулах, шуурхай мэдээллийг үнэн зөв солилцох, Гал унтраах анги, Эрэн хайх аврах салбар бүлгүүдийг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Онцгой байдлын газрын утасны жагсаалтыг цаг тухай бүрд нь шинэчилэн нийт бие бүрэлдэхүүнд болон Онцгой байдлын ерөнхий газарт таницуулан мөрдөж ажиллаж байна. Харилцаа холбооны тухай хууль, Радио үелзэл ашиглах журмын дагуу, Харилцаа холбооны газар, Онцгой байдлын ерөнхий газруудаас зөвшөөрөгдсөн үелзэл долгион дээр ажиллаж долгион ашиглалтыг сайжируулан ажиллаж байсан.

Тус газраас гамшиг, осол гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Монгол улсын Шадар сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталсан нэгдсэн удирдамжийн хүрээнд Гэр хороололын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах, Онцгой байдлын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр батласан удирдамжаар Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулийг дагаж мөрдөх Гэр хорооллын айл, өрхүүдийн пийшин зуухын галын аюулгүй байдлын стандарт норм, нормативыг хэрэгжүүлэхийн ач холбогдол, эрсдлийг тайлбарлан таниулах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх заавар зааварчилгааг ухуулан суртчилах талаар зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Шалгалтад Зуунмод сум дахь Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр анги, Мөнгөнморьт сум дахь Гал түймэр унтраах, аврах 75 дугаар анги, Зуунмод сум дахь Эрэн хайх аврах салбар

албан хаагчид төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулан Гэр хорооллын айл, өрхүүдийн галын аюулгүй байдлын стандарт норм, нормативыг шалгаж нийт 630 айл өрх хамрагдсан бөгөөд үзлэг шалгалтаар 513 зөрчил дутагдал илрүүлж, 423 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, 1270 иргэнд галын аюулаас урьдчилан сэргийлэх, цахилгааны хэт ачаалал үүсгэхгүй байх, бага насны хүүхдийг болзошгүй ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлэх гарын авлага материал 450 ширхгийг тараан заавар, зөвлөмж өгч галын аюулаас урьдчилан сэргийлэх болон пийшин зуухны аюулгүй байдлыг хангах талаар ухуулга сурталчилгаа хийж дүгнэж ажилласан. Нийт:

- Яндангийн залгаа буруу – 169
- Пийшин, зуухны түгжээ зөрчилтэй – 134
- Цахилгааны утас гэмтэлтэй – 189
- Үнс нурма ил задгай хадгалах – 107
- Яндан зуухтай шатах материал ойрхон – 34
- Асран хамгаалах хүнгүй бага насны хүүхэд – 51
- Гэр хоорондын зай 5 метрээс ойрхон – 17
- Пийшин, зуухны доор 70х50 хэмжээтэй үл шатах материал байрлуулаагүй - 28
- Ил задгай өвс хураасан – 21
- Асран хамгаалагчгүй гэртээ бага насны хүүхэд үлдээсэн – 4

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 25 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 152-н зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 79 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгч ажилласан байна.

Аймгийн хэмжээнд баригдах 2 барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичиж холбогдох дансанд зураг хяналтын 100,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Барилга байгууламж шинээр ашиглалтад оруулах байнгын ашиглалтад авах улсын комисст 1 удаа орж ажиллалаа.

Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 12-н аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгож ажиллаа.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдрийг угтаж Онцгой байдлын газраас Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн бага, дунд ангийн сурагчдад гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, Онцгой байдлын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор "Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв"-тэй танилцуулах арга хэмжээг зохион байгуулж явууллаа. Тус арга хэмжээнд 16 бүлгийн 871 хүүхдийг хамруулав. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газарт Онцгой байдлын газраас зохион байгуулж буй ангиллын сургалтын СМ-1 мэдээ, урьдчилан сэргийлэх ажлын тоон үзүүлэлтийг цахим хаягт байршуулахаас гадна 7 хоног бүрийн баасан гаригт цаасан хэлбэрээр хүргүүлэн ажиллаж байна.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрт урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор ангиллын сургалт зохион байгуулах удирдамж гарган батлуулж, Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн алба хаагчид, мэргэжилтэн, Гал түймэр унтраах, аврах 24, 75 дугаар анги, Эрэн хайх, аврах салбар, бүлэг, Зуунмод сум дахь 07 дугаар ангийн алба хаагчнартаа хамтран ангиллын сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж 7 удаагийн 14 цагийн сургалтаар 188 ажилтныг хамрууллаа.

2022 онд НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас "Иргэд, олон нийтэд хүргэх эрт сэрэмжлүүлэг, арга хэмжээ, уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх болсонтой холбогдуулан аймгийн Эрүүл мэндийн газрын ажилтан, алба хаагчдад гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг аймгийн Улаан загалмайн хорооны арга зүйч Б.Нямгалтай хамтран зохион байгуулан ажиллалаа.

Тус сургалтаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар, Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бэлэн байдлаа хангах болон Гамшгаас хамгаалах тухай хуулиар нийт 32 ажилчдыг хамруулан 4 төрлийн гарын авлага 76 ширхгийг тараан холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчиллаа.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдрийн хүрээнд Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн ахлах, бага, дунд ангийн багш, Зуунмод сумдахь политехник коллежийн багш, ажилчдад гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох танхимын сургалтыг зохион байгуулж явууллаа.

Тус сургалтыг зохион байгуулснаар багш нараар дамжуулан Хүмүүн цогцолбор сургуулийн сурагчдад болон Политехник коллежийн оюутнуудад гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох зорилготой юм. Сургалтад нийт 100 гаруй багш, ажилчдыг хамруулж 3 төрлийн гарын авлага 258 ширхгийг тараан ажилласан байна.

Төв аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 24 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн Зуунмод сумын гэр хорооллын айл өрхүүдэд Галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан удирдамжийн дагуу “Аюулгүй галлагаа” нэгдсэн арга хэмжээг 2022 оны 10 сарын 05-17-ны өдрүүдэд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд гэр байшингийн галын аюулгүй байдлыг хангах, цахилгааны хэт ачаалал үүсгэхгүй байх, бага насны хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, пийшин зуухны аюулгүй ажиллагааг хангаж, угаарын хийнээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдлээс өрхгэрээ хамгаалах талаар ухуулга сурталчилгаа хийж, иргэдэд мэдээлэл сурталчилгаа, сэрэмжлүүлэг хүргэж ажиллалаа.

Тус шалгалтаар нийт Зуунмод сумын 5 багийн гэр хорооллын 847 өрхийн 3304 иргэнд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг хийсэн бол тус сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах гал түймэр гарах эрсдэлтэй барилга, орон сууцанд амьдардаг 51 өрхийн 198 иргэнд ухуулга сурталчилгаа хийж, 4 төрлийн гарын авлага 5897 ширхгийг тараан ажилласан байна.

Орон нутгийн TBS телевизээр цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухай бүр телевизээр дамжуулан ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 68 удаа хүргэн ажилласан.

Бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь цоожлон үлдээхгүй байх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж гэр, орон сууцны цахилгааны аюулгүй байдлыг хангаж, үр хүүхдийнхээ аюулгүй орчинг цаг ямагт бүрдүүлж байх чиглэлээр “Ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлье” сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж, TBS телевизээр ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 100 удаа хүргэн ажилласан.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 29 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 5 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 5 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 16 удаа нийт 26 удаагийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Мөн байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээний постер, бичлэгүүдийг цаг тухай бүр хийн нийт 9 төрлийн постер 2 төрлийн видео бичлэгийг байршуулсан.

Эрэн хайх ажиллагаа:

Эрэн хайх аврах ажиллагааны дуудлага-3

Гал түймрийн нөхцөл байдал: Объектын гал түймэр-4, ой, хээрийн түймрийн дуудлага-2, мэдээлэл-2 ирсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд штабын даргын 2020 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн баталсан төв, орон нутгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах ангиудад зохион байгуулах Гал түймэр унтраах, аврах бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх нэгдсэн арга хэмжээний удирдамжийн дагуу Онцгой байдлын газрын даргаар төлөвлөгөөг батлуулан ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын дэд даргын баталсан төв, орон нутгийн онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах ангиудад зохион байгуулах “Гал түймэр унтраах, аврах ангийн бие бүрэлдэхүүнд зохион байгуулах сургалт” нэгдсэн арга хэмжээний хөтөлбөрийн дагуу Газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн даргаар төлөвлөгөөг батлуулж, Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүнд Гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга зам, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм, ажлын байран дээрх хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйл, түүнийг бууруулах арга зам, Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний чиг үүрэг, Онцгой байдлын байгууллагын тусгай зориулалтын болон шуурхай албаны автомашины ашиглалт болон анхаарах зарчим асуудал, Онцгой байдлын байгууллагын автомашин, техникийн засвар, үйлчилгээ хийх үеийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Гал түймэр унтраах, аврах ангийн өдөр тутмын цагийн цагийн хуваарь, Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм, Гал түймэр унтраах дүрэм, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, Гал түймэр унтраах автомашины жолоодлогын дадлага сургалт, Гал унтраах багаж хэрэгсэлтэй ажиллах дадлага сургалт зэрэг сэдвээр танхимийн болон практик дадлага сургалтын ажлуудыг тус тус зохион байгуулж ажиллалаа.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгаль орчин, Газар геодези зураг зүйн хяналтын чиглэлээр:

Газрын даргын баталсан 19/48 дугаар удирдамжийн хүрээнд Архуст, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт сумын Засаг дарга, Газрын даамал нарын 2020-2022 оны эхний хагас жилийн газар олголтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, хуульд нийцээгүй шийдвэр гаргасан, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.4, 55 дугаар зүйлийн 55.1 дэх заалтыг зөрчиж олгосон нийт 105 нэгж талбарыг хүчингүй болгох улсын байцаагчийн 23 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.

Иргэнээс ирүүлсэн 3 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр :

Төв аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг Төв аймгийн Заамар сумын нутагт ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудын нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах ажлын хэсэгт томилогдож ажиллалаа.

Газрын даргын баталсан 19/33 дугаартай удирдамжийн дагуу Төв аймгийн Заамар сумын Хайлааст 3-р багийн нутагт Заамар гоулд ХХК-ийн эзэмшлийн тусгай зөвшөөрлийн талбайд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гурвалсан гэрээ байгуулалгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан Нутгийн буян нөхөрлөлийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож, тусгай зөвшөөрөл эзэмшигч Заамар гоулд ХХК-д 1 заалт бүхий албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулж ажиллаа.

Төв аймгийн Прокурорын газраас харьяаллын дагуу шилжиж ирсэн Төв аймгийн Заамар сумын Хайлааст 3-р багийн нутагт байрлах Алтан нутгийн андууд нөхөрлөлд холбогдох “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам зөрчсөн” гэх хэрэгт Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 1.500.000 төгрөгөөр торгох шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулж ажиллаа.

Төв аймгийн Прокурорын газраас харьяаллын дагуу шилжиж ирсэн Төв аймгийн Баянчандмань сумын нутагт байрлах Наранбулаг амралтын газарт холбогдох “Зохих зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон” гэх хэрэгт Зөрчлийн 2234000769 дугаартай хэрэг үүсгэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

Төв аймаг дахь Цагдаагийн газраас Төв аймгийн Батсүмбэр сумын Мандал 1 дүгээр багийн нутагт зохих зөвшөөрөлгүйгээр түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 200,000 төгрөгийн торгуул арга хэмжээ авч Прокурорын хяналтад хүргүүлсэн.

Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр:

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 19/03 дугаартай “үйлдвэрийн осол, хурц хордлогын актыг хянан баталгаажуулах тухай” удирдамжийн дагуу УЦУОШТөв, Илт гоулд, Монвольфрам ХХК-д гарсан 3 үйлдвэрийн ослын актыг хянан баталгаажуулж, Бүрдэл майннинг, Эл си би ХХК-д гарсан 2 үйлдвэрийн ослыг хянаж байна. Мэргэжлийн хяналтын газрын 19/54 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Архуст, Баянжаргалан, Баян суманд шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн чанар, угсралтын үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал хангаж байгаа эсэхэд хяналт шалгалтыг хийлээ.

Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр:

Иргэн Н.Сүхбаатараас ирүүлсэн өргөдлийн дагуу газрын даргын баталсан 19/59 дугаартай удирдамжаар “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт”-ыг Төв аймгийн Засаг даргын тамгын газар хийж, тухайн иргэнд 410 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.

Харилцаа холбооны хяналтын чиглэлээр:

Монгол улсын Засгийн газрын 318 дугаар тогтоолын дагуу Батсүмбэр суманд баригдсан 12 айлын орон сууцны барилга, Эрдэнэсант сум Угалз баг Цагаан өндөр хайрханы оройд баригдсан Мобиком ХХК-ны үүрэн холбооны станцын сайтын барилгыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж 6 үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Барилга байгууламжийн ашиглалтын шаардлага хангасан тухай ногоон гэрчилгээг Мобиком ХХК-д хүргүүлж ажилласан.

Эрүүл ахуй халдвар, хамгааллын хяналтын чиглэлээр:

Шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн эрүүл ахуйн нөхцөлийн талаар баталгаажуулах хяналтын хийж улсын байцаагчийн 7 дүгнэлт гаргаж, 2 удаа улсын комисст оролцож, тусгай зөвшөөрлийн дүгнэлт 1-ийг гаргаж ажилласан.

Хүнсний чанар, стандарт, эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:

"Төв нутгийн Алтан намар-2022" үзэсгэлэн худалдаа Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн "Food City Mall" худалдаа үйлчилгээний төвд зохион байгуулагдаж 27 сумын төмс, хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний худалдаалалтад хяналт тавьж ажилласан.

Боловсролын хяналтын чиглэлээр:

Өдөр өнжүүлэх бүлгийн үйл ажиллагаанд Зуунмод суманд 2 аж ахуй нэгжийг хамруулан тандалт судалгаа хийж, улсын байцаагчийн 14 заалттай 2 зөвлөмж гарган ажилласан.

Эрүүл ахуй халдвар, хамгааллын хяналтын чиглэлээр:

Озон эмчилгээний тандалт судалгааг Аймгийн нэгдсэн эмнэлэгт хийж зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан.

Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын чиглэлээр:

Ургамал хамгаалах химийн бодис, бордооны хэрэглээний тандалт судалгаанд 7 сумын 30 аж ахуй нэгж, иргэний /2 хүлэмжийн аж ахуй, 20 төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч, үр тариа эрхлэгч 4 аж ахуй нэгж, ХХААДС 1, УНС 2, үзэсгэлэн худалдаанд ирсэн 6 иргэн, 1 бордооны үйлдвэр/-ийг хамруулан тандалт судалгаа хийсэн.

Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын чиглэлээр:

МХЕГ-ын 01/97, аймгийн МХГ-ын даргын 19/50 дугаартай удирдамжийн хүрээнд Цээл, Жаргалант Эрдэнэсант, Сүмбэр, Угтаал цайдам сумдын 10 аж ахуй нэгжийн 2022 онд тариалсан үрийн улаанбуудайн дээжинд мэдрэхүйн аргаар үзлэг хийж 2 аж ахуй нэгжийн 7 дээжийн авч ХАБҮЛЛ-т тарих үрийн чанар, ургамлын өвчин, хортны шинжилгээнд хамруулсан. Одоогийн байдлаар шинжилгээний хариу гараагүй байна.

Бусад:

Тогтвортой хөгжил-Боловсрол сэдэвт 21 аймаг, нийслэлийн боловсролын хяналтын улсын байцаагчдын сургалтад Хүнсний хангамж-Аюулгүй байдал МАА-н үндэсний чуулганд мал үржлийн хяналтын улсын байцаагч хамрагдсан.

Хэнтий, Сэлэнгэ аймагт МХЕГ, нийслэл, 18 аймгийн МХГ-ын Ургамал хамгааллын хяналтын улсын байцаагчид тариалангийн талбайд мал орсны улмаас учруулсан хохирол, нөхөн төлбөр тооцох талаар сургалтад оролцсон.

Сорилтын нэгдсэн лаборатори нь:

Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь хяналт шалгалтын болон аж ахуй нэгжийн хүрээнд нийт 39 дээжинд 107 үзүүлэлт /хоолны 5 сорьцонд 18, Мах махан бүтээгдэхүүн 4 сорьцонд 15, Мах махан бүтээгдэхүүн /гадаад хяналт/ 2 сорьцонд 2, төрөл бүрийн самар /хуш модны самар/ 3 сорьцонд 3, сүү бүтээгдэхүүн /гадаад хяналт/ 2 сорьцонд 2, гүний усны 16 сорьцонд 48, төвлөрсөн системийн ус 3 сорьцонд 9, Савалсан ус 2 сорьцонд 6, Гемодиализ ус 2 сорьцонд 6./ үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан. **Үүнээс:** Стандартын шаардлага хангаагүй 5 сорьц 5 үзүүлэлт байна.

Эрүүл ахуй химийн лаборатори нь хяналт шалгалтын болон аж ахуй нэгжийн хүрээнд нийт 27 сорьцонд 120 үзүүлэлтээр /гурил гурилан бүтээгдэхүүний 3 сорьцонд 6 үзүүлэлтээр, төмс хүнсний ногооны 6 дээжинд 12 үзүүлэлтээр, Савласан ус 1 дээжинд 11 үзүүлэлтээр, гемодиализын ус 2 дээжинд 10 үзүүлэлтээр, гүний ус 4 дээжинд 52 үзүүлэлтээр, хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн 3 дээжинд 9 үзүүлэлтээр, дарсанд 1 дээжинд 1 үзүүлэлтээр, хоолонд 6 дээжинд 6 үзүүлэлтээр, төвлөрсөн системийн ус 1 дээжинд 13 үзүүлэлтээр/ эрүүл ахуй химийн шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан байна. **Үүнээс:** Стандартын шаардлага хангаагүй дээж илрээгүй болно.

Нэгж лабораториудад: нийт 66 сорьцонд 227 үзүүлэлтээр шинжилгээг хийж үр дүнг цаг хугацаанд нь хянаж, баталгаажуулан гаргасан.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Авлигатай тэмцэх газартай хамтран Авлигын эсрэг хуулийн сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газар, Зуунмод, Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар, Төв аймаг дахь Цагдаагийн газрын албан хаагчдад зохион байгуулж нийт 225 хүнийг чадавхжууллаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах төрийн албан хаагчдын Монгол хэлний зөв бичгийн дүрэм, найруулга зүйн чадварыг дээшлүүлэх, баримт бичиг зохион бүрдүүлэх, боловсруулах ажлыг сайжруулах, соён гэгээрүүлэх зорилгоор "Албан хэрэг хөтлөлтийн соёлыг дээшлүүлье" сэдэвт аяныг аймгийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 20-ноос 12 дугаар сарын 05-ныг хүртэл 45 хоногийн хугацаанд зохион байгуулж байна. Аяны хүрээнд төрийн албан хаагчдын дунд илтгэлийн уралдаан болон албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр ажил мэргэжлийн уралдааныг тус тус зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангалаа.

Аймгийн Насан туршийн боловсрол төвтэй хамтран аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын харьяа хэлтэс агентлагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад Монгол бичгийн анхан, дунд шатны сургалт, монгол хэлний найруулга зүйн 1 сарын хугацаатай сургалтыг эхлүүлж 32 байгууллагын 34 албан хаагчийг хамрууллаа.

Аймгийн Засаг даргын харьяа, хэлтэс агентлаг, 27 сумын архив, албан хэрэг хөтлөлтийн хариуцсан ажилтнуудад архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын талаар цахим уулзалтыг зохион байгуулж арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Төрийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг зохион байгуулж 16 байгууллагын байнга, түр, 70 жил хадгалах бүртгэл, устгах хэргийн актыг хэлэлцэн төрийн байгууллагад зөвлөмж чиглэл хүргүүллээ.

Хүний эрхийн үндэсний комиссын Төв аймаг дахь салбар, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран 27 сумын Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн мэргэжилтэн, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн тасаг, Багийн засаг дарга нарт туслах малчинтай байгуулах хөдөлмөрийн гэрээний онцлог, гэрээ байгуулах хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар цахим сургалт зохион байгуулж 107 албан хаагчийг хамрууллаа.

Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/365 дугаар захирамжаар байгуулан ажиллаж байна. 2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар 8116 иргэнд тоон гарын үсэг олголоо.

Ус хангамжийн эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвийн цэвэр усны нөөц сангийн барилга байгууламж, ундны усны эх үүсвэрийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/583 дугаар захирамжаар томилон Зуунмод, Сэргэлэн суманд эрсдэлийн үнэлгээ хийлээ.

ТӨРИЙН АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Төрийн архивын эх баримтаас байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 133 иргэний хүсэлтийг хүлээн авч 595 хуулбар хувь олгож, 54 лавлагаа, 161 хөмрөгийн 537 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан лавлагаа үйлчилгээ үзүүлж орон нутгийн төсөвт 758,0 төгрөгийг орууллаа.

3 хөмрөгийн 11 хадгаламжийн нэгжийн 1150 хуудас баримтын 11975 хүний нэр, 958 заалтын тоо, 958 тушаалын тоог мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, 3 хөмрөгийн 11 хадгаламжийн нэгжийн 1150 хуудас баримт скайнердаж 1 хөмрөгийн 11 хадгаламжийн нэгжийн 985 заалтыг pdf.jpeg хэлбэрт хувиргаж, 958 заалтын 1150 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож 1150 хуудас баримтыг фотошопоор сэргээн засварлаж цахим бааз үүсгэлээ.

Баримтын нөхөн бүрдүүлэлтээр “Хустайн шил ХХК” Баянцогт сумын гуна багийн 0,4 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам ажлын 2 хадгаламжийн нэгж, Хустайн шил ХХК” Баянцагаан сумын 0,4 кв-ын шугамын шинэчлэлийн 2 хадгаламжийн нэгжийг хүлээн авч баримтын тоо бүртгэл хөтлөн хадгаламжийн санд бүртгэлээ.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 64514 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138355 газар өмчлөх эрхийн 52890 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 1171 (10 сард хүлээн авсан мэдүүлэг -1171)

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 260,8 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 1,652,2 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 7,1 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2882 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 36 нэмэлт өөрчлөлт, шинээр 26 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 0, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 32, бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 3 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 28 лавлагаа өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого нийт 14,7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 650 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 180 хэргээр буюу 38.2 дахин их хувиар өссөн, гэмт хэргийн илрүүлэлт 50 хувь, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6 хувиар өссөн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-11, албадан саатуулагдсан-18, шүүхээр баривчлагдсан-35 нийт 64 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу эрүүл мэндийн үзлэг хийсэн. Эрүүлжүүлэгдсэн 11 иргэнээс 45650 төгрөг, хугацаа дууссан 40 иргэнээс 2,5 сая төгрөгийн төлбөр авч орон нутгийн төсөвт орууллаа.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Олон нийтийг хамарсан 1, чиглэлийн 1, зочны 2 хамгаалалт, олон нийтийг хамарсан 6 арга хэмжээнд нийтийн хэв журам сахиулж давхардсан тоогоор 14 тээврийн хэрэгсэл, 103 алба хаагч ажиллалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр

2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүртэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 72 жолоочийг илрүүлж, 54 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 18 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэлээ.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 4001 жолоочийг 116,4 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 78 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулж ажиллалаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Криминалистикийн шинжилгээ-179, магадлан шинжилгээ-217, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-484, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-1198, гарын хээний санг дардсаар баяжуулсан-669 мөрөөр баяжуулсан-85, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-696, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-203, гистологийн шинжилгээ-217 тус тус хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлб эл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
10-р сар	217	659	9	867	539	328	62.2
	4587209.8	3264531.0	178844.7	7672896.1	2601550.6	5071345.5	


ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь MC 41/QMS 036 19 тоот гэрчилгээтэй ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын баталгаажуулалтын 3 дах удаагийн давтан үнэлгээнд хамрагдах ажлын хүрээнд байгууллагын дотоод үйл ажиллагаа сайжруулах, ажилтан албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч судалгааны үр дүнг байгууллагын дотоод шуурхайд танилцуулахаар нэгтгэж байна.


Асуулт- 1 Судалгаанд хамрагдсан албан хаагчийн насны бүлэг

График - 1



Асуулт-2 Судалгаанд хамрагдсан албан хаагчдын хүйсийн харьцаа

График-2



Шинэ санаачилгатай 7 хоног ажлын хүрээнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс “Эмх цэгцтэй – Эртэч 7 хоног” аяныг зарлаж албан хаагчдын ширээ болон өрөө тасалгааны эмх цэгцийг сайжруулах талаар санамж, мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.



Аймгийн Засаг даргын орлогчын баталсан удирдамжийн дагуу “Тогтвортой амжиргаа 3” төсөлтэй хамтран Албанбулаг, Архуст сумын төрийн албан хаагчид болон иргэдэд Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу танилцуулах болон мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа.

“Сурагчдын хичээл, сурлагын хоцрогдол нөхөх, арилгах төлөвлөгөө”, “Хүүхдэд ээлтэй дотуур байр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт болон “Хүүхэд бүр цэцэрлэгт” дэд хөтөлбөр, “Төгсөлтийн аргачлал” төсөл хөтөлбөрийн 2021-2022 оны нэгдүгээр үе шатны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээний хийж дүгнэлт, зөвлөмжийг холбогдах газарт хүргүүдээд байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын чиглэлээр:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Засаг даргын тусгай сан, ОНХС, Төв Чандмань ДЭХГ-ын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын Бүжинхэн, Дэгдээхий, Ирээдүй, Унагалдайн андууд, Хүмүүн цэцэрлэгүүд, 4-р сургууль, 5-р сургууль, Хүмүүн цогцолбор цэцэрлэг, Бумбардай цэцэрлэг, Зуунмод сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв, Хот тохижуулах газар, Баруун Зуунмод ББН өрхийн ЭМТ, ГБХЗХГ, аймгийн музей, Насан туршийн боловсролын төв, Аймгийн ИТХ, Заамар сумын МСҮТ, Архуст, Баян, Баянжаргалан, Баянцогт, Аргалант, Лүн, Баянхангай, Угтаалцайдам, Цээл, Заамар, Жаргалант, Сүмбэр сумдын сумдын төсөвт байгууллагуудын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, Баянцагаан сумын ЭМТ, Мөнгөнморьт сумын ЗДТГ, Татварын хэлтэс, ОНХ-ийн сан, ЭЭС, Сумдын сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, өргөдлөөр аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тус тус хийж 5,838,955.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж үүнээс 390,265.3 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 2,173,358.5 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 3,186,989.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллаа. Өмнөх оны актын үлдэгдэл 171,193.5 мянган төгрөгөөс 81,498.7 мянган төгрөг, 2022 онд тогтоосон актаас 195,969.9 мянган төгрөг тус тус барагдсан байна.

ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө эхний 09-р сарын байдлаар орон нутаг 19895.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 20349.6 сая төгрөг төвлөрүүлж 102.3 хувьтай, 454.5 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 4321.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 5704.9 сая төгрөг төвлөрүүлж 132.0 хувьтай, 1383.4 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 2488.7 сая төгрөгөөр биелж, 109,0 %-

тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Батсүмбэр, Баяндэлгэр, Баянцагаан, Заамар, Мөнгөнморьт, Эрдэнэ, Зуунмод зэрэг 7 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баян, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцогт, Борнуур, Дэлгэрхаан, Лүн, Сүмбэр, Угтаал, Эрдэнэсант зэрэг 12 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Баянхангай, Баянчандмань, Бүрэн, Жаргалант, Өндөрширээт, Цээл зэрэг 7 сум, 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан Сэргэлэн сум байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

Сумдад 2022 оны 09 сарын байдлаар нийт 48400.0 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Орон нутгаас Боловсрол шинжлэх ухааны байгууллагад 9056.9 сая төгрөгийн санхүүжилт
-Эрүүл мэндийн байгууллагад 506.6 сая төгрөгийн санхүүжилт
-Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 18737.7 сая төгрөгийн санхүүжилт
-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 19250.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар:

2022 оны 09-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 153.7 сая төгрөгийн авлага, 272.8 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 172.0 сая төгрөг буюу 63.0 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 2.8 сая төгрөг буюу 1,04 хувь нь цалингийн өглөг, 1.7 сая төгрөг буюу 0.65 хувь нь НДШимтгэлийн өр, 25.2 сая төгрөг буюу 9.26 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 71.1 сая төгрөг буюу 26 хувийг бусад өр эзэлж байна.

**ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:**

Нэг. Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр

Хөрөнгө оруулалт: Аймгийн хэмжээнд 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 59,489.7 сая төгрөгийн 97 төсөл, арга хэмжээг тусган баталж үүнээс тендер шалгаруулалт зохион байгуулахаар 59,334.7 сая төгрөгийн 86 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. 2022.04.29-ны өдөр Монгол Улсын Их Хурал 2022 оны улсын төсөвт тодотголоор 621.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг зогсоосон.

2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах зорилтын хүрээнд 10 дугаар сарын байдлаарх худалдан авах ажиллагааны явцын мэдээлэл:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 39,759.7 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээнээс 39,559.7 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнд 38,151.8 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан. Соёлын яамнаас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 20.0 сая төгрөгийн бараа нийлүүлэх тендерт 1 оролцогч оролцож үнэлгээний хорооноос үнэлгээг хийж шаардлага хангахгүй байгаа тул татгалзаж дахин зарлахаар, Сангийн сайдын шийдвэрээр Жаргалант сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажлын тендерт оролцогч оролцохгүй байгаагаас шалтгаалж дахин зарласан.

2. Аймгийн шилжих үлдэгдлээс нийт 6,424.6 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээнээс 3,054,6 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулж, Аймгийн түвшинд зарлах Цахим засаглал хөтөлбөрийн 100.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээнд тендер зарласан боловч оролцогч оролцохгүй дахин зарласан. Мөн 3 тэрбум төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, Байгаль орчин аялал жуулчлалын газрын авто машин худалдан авах тендерийг дахин зарлах эсэх талаар захиалагч байгууллагад хандаж хариу хүлээж байна. Сумдад эрх шилжүүлсэн ажлуудаас Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх ажилд Батсүмбэр сумын 100.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний тендерийн нээлт 2022.10.21-нд хийгдсэн 1 компани оролцсон үнэлгээний хороо үнэлгээг хийж байна. Бүрэн сумын хувьд тендер шалгаруулалтыг зарласан боловч оролцогч оролцоогүй дахин зарлана. 2022.10.26-ны байдлаар зарлаагүй хүлээгдэж байна.

3. Аймгийн Замын сангийн хөрөнгөөр нийт 2,742.6 сая, төгрөгийн 3 ажлаас 2,222.6 сая төгрөгийн төсөвтэй 2022 онд 190.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх 1 төсөл, арга хэмжээ, Сэргэлэн, Лүн, Зуунмод сумдын авто замын зураг төсөл боловсруулах 120.0 сая төгрөгийн 1 ажлын тендер зарлаж 289.2 сая төгрөгийн гэрээг байгуулсан. Мөн 400.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж захиалагч үнэлгээний хорооны дүгнэлтийг 2022.10.17-нд цахим

системд үр дүнг нийтлэж ажлын 6 хоног хүлээсэн гомдол гараагүй тул захиалагч гэрээ байгуулах шатанд хүлээгдэж байна.

4. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ОНХСангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс 10 дугаар сарын байдлаар захиалагч байгууллагад нийт 4,559.4 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулах эрхийг олгож гэрээ бүрэн байгуулагдсан. Сумдад эрх шилжүүлсэн ажлаас Заамар сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын 100.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний тендерийг зарласан. Оролцогч оролцохгүй байгаа шалтгаанаар Батсүмбэр сумын Спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах 60.0 сая төгрөгийн Баянцагаан сумын Гэр хороолол, нийтийн орон сууц, үйлчилгээний газруудыг халаалтад холбох 80.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг дахин зарлахаар захиалагч шийдвэрлэсэн. 2022.10.31-ны байдлаар зарлагдаагүй байна.

5. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,206.9 сая, төгрөгийн 6 төсөл, арга хэмжээнд 100 хувь тендер зарлаж, 6 ажилд 1.161.1 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна.

6. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар нийт 608.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд тендер зарлахаас гэрээ байгуулагдсан 244.0 сая төгрөгийн 3 ажил, хэлэлцээрийн үр дүнгээр гэрээ байгуулагдах 300.0 сая төгрөгийн 1 ажил нь ажлын 6 хоног хүлээж, гэрээ байгуулах шатанд байна. Захиалагчийн шийдвэрээр 64.0 сая төгрөгийн 1 ажилд гэрээ байгуулагдсан.

7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын эрүүл мэндийн төвийн 2022 онд шаардагдах: 1 төсөл, арга хэмжээ-дотроо нийт 32 багцтай 1,600.0 сая, төгрөгийн төсөвт өртөгтэй бараа худалдан авах тендерийг зарлаж 32 багцад шалгаруулалт хийж, гэрээ байгуулагдсан.

8. Гадаадын хөрөнгө оруулалтаар Япон улсын хөрөнгө оруулалтаар Хүмүүн цогцолбор сургуулийн барилгын дотор засварын ажлын тендерийг 2 дахь удаагаа зарласан Шинэчлэл-инвест ХХК шалгарч 850.5 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

ХОЁР. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Хөгжлийг тэтгэсэн томоохон дэд бүтцийн ажлуудаас:

- Дулааны станцын халаалтын 1,2,3,4,5,6,7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, гинэчлэлийн ажлыг “Эл Си Би” ХХК-тай 11590,4 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 7-р хэсгийн 347м шугам сүлжээг байгуулах ажлыг гүйцэтгэн ашиглалтад орууллаа.
- Зуунмод сумын үерийн ус зайлуулах байгууламжийн ажлыг Ноблрөөд ХХК 428.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан 400м сувгийн бетон цутгалт, 22м урттай гүүр хоолой, 4 хоолой цутгалтын ажил хийгдэж, далангийн цутгалтын ажил хийгдэж, ашиглалтад орууллаа.
- Зуунмод сумын цэвэр усны 1, 3-р өргөх насосны станцын шинэчлэлтийн “Ар булаг” ХХК, 1334.1 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. 1-р өргөх станцын барилга баригдсан. 3-р өргөх станцын барилга засвар хийгдэж, 39 кВт-ын давтамж хувиргагч, 2ш инвертерийн холболтын цахилгааны ажил, нөөц шугамын угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.
- 2000 айлын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Төв, Зуунмод сум/ ажлыг “Мета менежмент” ХХК 6036.4 сая төгрөгөөр гэрээ байгуулан ажил гүйцэтгэж байна. Улаан шугам тавигдаж, дулаан хангамжийн шугам сүлжээний угсралтын ажил хийгдэж байна.
- Зуунмод хотын 1500 айлын орон сууцны хороолол шугам сүлжээ байгуулах ажилд 9,300.0 сая төгрөг батлагдан гүйцэтгэгчээр И Жи Өү ХХК шалгаран гэрээ байгуулсан. 2022 онд 750.0 сая төгрөг санхүүжилт хийдэх ба зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.
- Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төслийн хүрээнд 5 суманд төсөл хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагууд шалгарч ажилаа эхлүүлээд байна. Нийт 16,000.0 сая төгрөг төсөвлөгдөн 2022 онд 2200,0 сая төгтөг батлагдсан. Үүнд:
 - Борнуур суманд "Сайн констракшн" ХХК 3.8 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан. 2022 онд Бохир усны шугамын ажил 824.8 м шугам угсарсан, цэвэр усны 150 м шугам угсарсан, цэвэрлэх байгууламжийн ажил 2022 онд хийж дуусахаар төлөвлөгөөтэй ажиллаж байна.
 - Сэргэлэн суманд Баткмолект ХХК 4299,9 сая төгрөгөөр гэрээ байгуулан ариутгах татуургын шугамын ажил 100 хувь хийгдсэн, цэвэрлэх байгууламжийн угсралтын ажил 9 сарын 15-нд дуусахаар байна. Цэвэр усны шугам, Дулааны шугам, холбогдох цахилгаан, холбооны ажил 2023 онд хийгдэнэ.

- Эрдэнэ суманд Билгүүн од констракшн ХХК 4539.3 сая төгрөг ажил эхэлсэн. 2 худгийн угсралтын ажил дууссан, цэвэр усны шугамын угсралтын ажил хийгдэж байна. 2022 ондоо ус хангамжийн ажлын бүрэн дуусгах төлөвлөгөөтэй байна.
- Баянчандмань суманд Эл Си Би ХХК шалгаран гэрээ байгуулан 2 худгийн өрөмдлөгхийгдэж, барилга баригдаж байна. Усны нөөцийн сангийн суурийн нүх, цахилгаан хангамжийн ажил хийгдсэн.
- Дэлгэрхаан суманд Төв төгөл ХХК шалгаран гэрээ байгуулж ажил эхэлсэн. Гадна цэвэр усан хангамжийн шугам угсралтын ажил эхэлсэн нийт 400м хос шугамын ажил хийгдэж дууссан. 2022 онд гүний худаг угсралтын ажил дуусгах, өндрийн усан сан болон одоо байгаа шугам сүлжээнд холбох ажил хийгдэж дуусахаар ажиллаж байна.

Хот байгуулалтын ажлуудаас:

Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд энэ сард 14 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосноор 2022 онд нийт 76 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан батлаад байна.

Зураг төсөл боловсруулах даалгавар батлах, ажлын хүрээнд энэ сард 3 зургийн даалгавар баталснаар 2022 онд нийт 40 зураг төсөл боловсруулах даалгавар батлагдаад байна.

Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах, ерөнхий төлөвлөгөө батлах, ажлын хүрээнд энэ сард 22 зураг төсөл баталснаар 2022 онд нийт 150 зураг төсөл зөвшөөрөлцөн батлаад байна.

Барилга, инженерийн байгууламжийн зураглалыг шалгаж, хот байгуулалтын мэдээллийн санд 12 гүйцэтгэлийн зураг хүлээн авч акт олголоо.

“Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах” дүрмийн хүрээнд :

Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг энэ сард 7 барилга байгууламжид олгосноор 2022 онд нийт 98 барилга, байгууламжид эхлүүлэх зөвшөөрөл олгоод байна.

Барилга байгууламж ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд энэ сард 11 барилга байгууламж ашиглалтад оруулснаар 2022 онд нийт 56 барилга байгууламж ашиглалтад ороод байна.

ГУРАВ.ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Газрын төлбөрийн талаар:

2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа Батсүмбэр сумын 5 нэгж талбар, Борнуур сумын 12 байршилд нэгж талбар, Сэргэлэн сумын 2 нэгж талбар, Эрдэнэ сумын 1 нэгж талбар, Мөнгөнморьт сумын 3 нэгж талбар нийт 23 нэгж талбарын газрын дуудлага худалдааны зарыг www.mle.mn сайтад баталгаажуулсан. Зуунмод сумын 1 нэгж талбарын төсөл сонгон шалгаруулалтыг баталгаажуулсан.

Газрын дуудлага худалдааны орлогоос өссөн дүнгээр 2,58 тэрбум төгрөг газрын биржийн дансанд төвлөрч аймгийн ИТХ-ын 2022,05,19-ны өдрийн 03 дугаар тогтоолын дагуу орлогыг сумдад хуваарилсан.

Газрын төлбөрийн орлого 2022.10.25 өдрийн байдлаар газрын төлбөрийн орлогоос 1800.0 сая төгрөг аймаг болон сумын дансанд төвлөрүүлсэн байна.

Газрын төлбөрийн нэхэмжлэл үүсээгүй 1985 нэгж талбарын хөрөнгийн бүртгэлийг үүсгэн 2022 оны газрын төлбөрийн нэхэмжлэлийг үүсгэсэн.

Суурь судалгаа мониторингийн ажлын хүрээнд:

Улсын хэмжээнд хийж гүйцэтгэсэн “Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн Газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах ажил”-ын хүрээнд зөрчилтэй гэж тогтоогдсон нэгж талбарын зөрчлийг хэрхэн арилгах зөвлөмжийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1765 тоот албан бичгээр ирүүлсэн. Тус зөвлөмжийн дагуу сумдад зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилгах чиглэлийг 09 дүгээр сарын 28-ны өдрийн 07/842 тоот албан бичгээр хүргүүлэн 596 нэгж талбарын зориулалт буруу бүртгэсэн зөрчлийг арилган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Газар зохион байгуулалт

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 121 дүгээр тогтоолын батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 3-р улирлын байдлаар өссөн дүнгээр 73675 иргэнд 13510.34 га газар өмчлүүлж газар өмчлөлийн явц 78 хувьтай байна.

2023 онд өмчлүүлэх газрын төлөвлөлтийн саналыг 26 сумаас хүлээн авч газар зохион байгуулалтын цахим системд боловсруулан танилцуулж байна.

Үүнд:

- Улсын чанартай зам дагуу шинээр өмчлүүлэх 858 иргэнд 67.15 га
- Эзэмшиж буй газрыг өмчлүүлэх 283 иргэнд 27.68 га
- Сумын төв болон суурин газарт шинээр өмчлүүлэх 3987 иргэнд 728.32 га
- Нөхөн олговортойгоор солих газар 1002 иргэнд 501 га
- Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр нь өмчлүүлэх 137 иргэнд 1.54 га

Нийт 6267 иргэнд 1325.69 га газрыг өмчлүүлэх төлөвлөөд байна.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 121 дүгээр тогтоолын батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 3-р улирлын байдлаар өссөн дүнгээр 73675 иргэнд 13510.34 га газар өмчлүүлж газар өмчлөлийн явц 78 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд газрын кадастрын мэдээллийн санд 10-р сард нийт 98 өргөдөл ирснээс 58 өргөдлийг шийдвэрлэж шинээр 40 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.

Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 12 дугаар хуралдаанаар дараах 2 асуудлыг хэлэлцүүлэн батлууллаа. Үүнд:

- Зарим газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтад авах тухай
- Иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг дэмжих тухай

ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн өмчийн хүрээнд: 2022 оны 10 дугаар сарын 04-09-ний өдрүүдэд ТӨБЗГ-т Эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын нэгдсэн программд нийт 324 байгууллагын тайланг баталгаажуулж, хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар Хөрөнгө шийдвэрлэх асуудлыг хэлэлцэн ИТХ-д арган барьж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулан дуудлага худалдааг зохион байгуулахаар зарыг “Монголын үнэн” сонинд нийтлүүлээд байна.

“Төв-Эрдэнэс” ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн гишүүдтэй “Эрдэнэсийн эрэг” ХХК -ийн ТУЗ-ийн гишүүд уулзаж, 34%-ийн хувьцааны асуудал, мөн ТУЗ-ийг шинэчлэх талаар санал солилцож цаашид хуулийн хүрээнд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн дараагийн ТУЗ гишүүд томилогдох хүртэл хугацаанд асуудлыг хойшлуулаад байна.

Түрээсийн орон сууцны хүрээнд: Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13, 2021 онд 1 өрх, нийт 26 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын төлбөрийг график хугацааны төлөлтөнд хяналт тавьж ажилласнаар 2022 оны 10 сарын байдлаар 26 айлын түрээсийн төлбөр 40,000,000 төгрөг төвлөрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 800.0 сая төгрөгийг шийдвэрлэн, тендерт Төв цогт өлзий ХХК шалгарч, 40 айлын орон сууц барилгын ажлын эхэлсэн Ажлын явц 60 хувьтай байна.

ТАВ. ЗАМ ТЭЭВРИЙН ЧИГЛЭЛЭЭР

Авто замын салбарын хүрээнд: Зуунмод-Хөшгийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлыг холбосон авто замын барилгын ажлыг 8161.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн. Зам барилгын ажлын гүйцэтгэгчээр Анандын зам компани шалгаран гэрээ байгуулан ажлын гүйцэтгэл 90 хувьтай хэрэгжиж байна.

Өвөлжилтийн арчлалтын ажлын хүрээнд : А0301 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замд 29-31 хооронд замын гулгаа халтиргаанаас хамгаалж 20тн давс цацаж, автогрейдерээр замын зорчих хэсгийн 2500м² талбайн цас цэвэрлэсэн.

ПК-47-ПК-70 хооронд автогрейдерээр зорчих хэсгийн 1500м² талбайд хусалт хийсэн байна. Цас цэвэрлэгч тоноглолтой авто машинаар 16000м² замын зорчих хэсгийн цасыг цэвэрлэж ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.

ЗУРГАА. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Мал аж ахуйн хүрээнд: Газар тариалангийн бүс 13 суманд мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлэн байдлыг шалгах ажлын хэсэг ажиллаж бэлтгэл ажлыг шалгаж ажиллалаа. Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд малчин, мал бүхий иргэд өнөөдрийн байдлаар 69502.0 тн хадлан, 6031.5 тн гар тэжээл, 22460.2 тн ногоон тэжээл, 3587.7 тн үйлдвэрийн тэжээл тус тус бэлтгэж, хадлан, тэжээл бэлтгэл 43.0% байна. Сумын аюулгүйн нөөцөд 482.2 тн өвс, 181.6 тн тэжээл нөөцлөөд байна.

Аймгийн аюулгүй нөөцөд 150 тн буюу 7500 боодол шинэ өвс нийлүүлэх ажлыг төрийн худалдан авалтын цахим хуудсанд нээлттэй зарласны дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/599 тоот захирамжаар байгуулсан “Үнэлгээний хороо”-ний гишүүд сонгон шалгаруулж, шалгарсан аж ахуйн нэгжид “Мэдэгдэл”-ийг хүргүүлсэн.

Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Хүнсний хангамж аюулгүй байдал-Мал аж ахуй” үндэсний чуулганд 27 сумдын мал аж ахуйн салбарын болон баялаг бүтээгчдийн төлөөлөл 45 иргэнийг хамрууллаа.

Үндэсний үүлдэр, омгийн малыг олон нийтэд сурталчлах, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг ирээдүй, хойч үедээ өвлүүлэн үлдээх, хүнсний хангамж аюулгүй байдалд оруулж буй малчид, үйлдвэрлэгчид, эрчимжсэн МАА эрхлэгчдийн хувь нэмрийг үнэлэх, урамшуулах зорилгоор жил бүр ХХААХҮЯ-аас уламжлал болгон зохион явуулдаг “Шилмэл мал-2022” үзэсгэлэн, худалдааг цахимаар зохион байгуулсан бөгөөд үзэсгэлэн худалдаанд Сэргэлэн, Батсүмбэр сумын 4 малчин, фермер оролцлоо.

Шинэ хөдөө төслийн хүрээнд Нутгийн Баянцагаан өсвөр хуцыг сайжруулагчаар сумдад нийлүүлсэн “Н Бэлэг” ХХК, Тал хээрийн зарим суманд Сэлэнгэ, Герефорд үхрийн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн “Үржлийн шилмэл сүрэг” хоршооны гүйцэтгэлийн тайланг хянаж сангийн яамны цахим хуудсанд байршуулж, санхүүжилтийг олгуулахаар уламжиллаа

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд үхэр сүргийг ээмэгжүүлэх ажлыг 18 сумын 91481 толгой үхэрт хийх бөгөөд одоогийн байдлаар Зуунмод, Сэргэлэн, Цээл, Заамар, Эрдэнэсант, сумдууд ээмэгжүүлэлтийн ажлыг сайн зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын зөвлөмжийн дагуу Хууль зүйн хэлтэс, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, орон нутаг дахь хүний эрхийн комиссын төлөөлөл, Үйлдвэрчний эвлэлийн төлөөлтэй хамтран “Туслах малчинтай байгуулах хөдөлмөрийн гэрээ”-ний онцлог, гэрээ байгуулах хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар сумдын удирдлага мэргэжилтнүүдэд цахим сургалтыг зохион байгуулсан.

Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээнд: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1585.0 мян.тол мал хамруулахаас дархлаажуулалт 101.6 хувьтай хэрэгжиж дууссан.

Гоц халдварт бог малын мялзан өвчин оношлогдсон Баян-өнжүүл сумын хязгаарлалтын дэглэм цуцлагдаж тайван байдалд шилжсэн. Аймгийн Засаг даргын А/468 тоот захирамжаар Баянцагаан, Баян, Баян-өнжүүл, Алтанбулаг, Сэргэлэн сумдад бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 708.8 мян.тол мал хамруулж 97.7 хувьтай хэрэгжлээ.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг аймгийн Засаг даргын А/518 тоот захирамж, Газрын даргын А/51 тоот тушаалаар 09 дүгээр сарын 15-наас эхлүүлэн МЭНС-д төлөвлөлт 100 хувь оруулж дархлаажуулалтад 413058 тол.мал хамрагдаж 97.8 хувьтай хэрэгжсэн.

Бүрэн, Өндөрширээт, Баян-өнжүүл, Алтанбулаг, Лүн, Дэлгэрхаан сумдад ажлын хэсэг томилогдон гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын явцтай танилцаж, 6 сумын 34 малын өрхийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэл хийсэн эсэхэд хяналт шалгалт хийлээ. Отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар малчдад заавар, зөвлөмж хүргэж ажилласан.

Малын эрүүл мэндийн үзлэгт 4100.0 мян.тол мал хамруулахаас 3493.2 мян.тол мал хамруулж 85.2 хувьтай, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 7943.2 мян.тол мал хамруулахаас 7790.7 мян.тол мал хамруулж 98 хувьтай, 1350 мян.м2 талбайд халдваргүйтгэл хийхээс 1185.6 мян.м2 талбай буюу 87.8 хувьтай тус тус хэрэгжиж байна.

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын удирдамжийг аймгийн Засаг даргын А/449 тоот захирамж, газрын даргын А/43 тоот тушаалаар сумдад хүргүүлэн, дархлаажуулалт 1099.1 мян.тол мал хамруулж 97.0 хувьтай хэрэгжлээ.

Боом, Галзуу, Томуу, Хонины цэцэг, Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын үйлчилгээний хөлсний материалын хүлээн авалт 100 хувьтай, Бруцеллэз, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын үйлчилгээний

хөлсний материалын хүлээн авалт 40 хувьтай, орон нутгийн үйлчилгээний хөлсний материалын хүлээн авалт 80 хувьтай байна.

Хүнсний хангамж аюулгүй байдал мал, аж ахуй үндэсний чуулганд 2 албан хаагч, Зэрлэг ан амьтны өвчлөлийн тандалт сэдэвт хэлэлцүүлэгт 2 албан хаагч хамрагдлаа. Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.5-д заасны дагуу 2022 онд мал эмнэлгийн цахим гэрчилгээ олгож, хяналт тавьж баталгаажуулах ажлын хүрээнд МЭЭГазраас цахим сургалт хийж зөвлөмж чиглэл өгсөн.

Тайлант хугацаанд 12973 мал, амьтан, 570.3 тн мах, махан бүтээгдэхүүн, 856 ширхэг арьс шир, 5 тн айраг, 448.1 тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 150 кг ноолуур, 42176 кг ноос, 28.1 тн дайвар бүтээгдэхүүнд 2518 мал эмнэлгийн гэрчилгээг олгож, 10 дуудлагын дагуу 54 малд үйлчилгээ үзүүлээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хяналтын цэг 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа нийт 605 тээврийн хэрэгсэл, адуу 1055, үхэр 1783, хонь 16484, ямаа 5692, тэмээ 24 нийт 25038 толгой амьд мал, 234033 кг мах, 450 ширхэг арьс шир, 7050 литр айраг, 23791 кг ноос, хялгас, 18.3 кг сүү сүүн бүтээгдэхүүн, 773 кг дайвар бүтээгдэхүүнд эрүүл ахуйн үзлэг хийн мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж, 1 зөрчил илрүүлэн хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэж ажиллалаа.

Газар тариалангийн хүрээнд: Аймгийн хэмжээнд ургац хураалт 10-р сарын 31-ны өдрийн байдлаар Үр тариа 55378 га-аас, 62153 тн, үүнээс: улаанбуудай 48998 га-аас, 53888 тн, төмс 12149 га-аас, 134505,7 тн, хүнсний ногоо 1817,5 га-аас, 20234,8 тн таримал тэжээл 12583 га-аас, 34934 тн, тосны ургамал 18993 га-аас, 6827 тн ургац тус хураан авсан байна. Аймгийн хэмжээгээр 258654,5 тн ургац хураасан. Аймгийн Засаг даргын А/557 захирамж, ургацын штабын 3-р хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх, ургацын мэдээний бодит байдалд хяналт тавих, сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэнд мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх зорилгоор Эрдэнэсант, Өндөрширээт, Лүн, Аргалант, Баянхангай, Заамар, Цээл, Угтаалцайдам, Баянцогт, Жаргалант, Борнуур, Сүмбэр, Баянчандмань, Батсүмбэр, Архуст, Баяндэлгэр, Сэргэлэн, Алтанбулаг, Эрдэнэ сумдад ажиллалаа.

Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд: Аймгийн хэмжээний жижиг дунд үйлдвэрлэгч аж ахуй нэгж, иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үйлдвэрлэгчээр хэрэглэгчдэд шууд, зах зээл, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилго бүхий "Төв нутгийн алтан намар-2022" үзэсгэлэн худалдааг Улаанбаатар хот дахь Төв аймгийн нутгийн зөвлөл ТББ, аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран Фүүд сити худалдааны төвд 10 дугаар сарын 07,08,09-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Үзэсгэлэн худалдаанд 27 сумын 254 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид (19 хоршоо, 36 аж ахуйн нэгж, 199 өрхийн аж ахуй эрхлэгч) 322 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож, 3 өдөрт 1,2 тэрбум төгрөгийн борлуулалтаар дэмжигдэж, Фүүд сити худалдааны төвд Батсүмбэр сум -сүү, Баянцагаан сум -мах, Борнуур сум -төмс, хүнсний ногоо цаашид нийлүүлж, борлуулах гэрээ хийсэн нь үзэсгэлэн худалдааны онцлох ажил боллоо.

ХХААХҮЯ-ны сайдын 2022 оны А/163 дугаар тушаалаар ЖДҮХСангаас аймгийн хэмжээнд 500.0 сая төгрөгийн зээлийн эх үүсвэр хуваарилагдсан.

Хуваарилагдсан эх үүсвэрийн хүрээнд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, 29 аж ахуйн нэгжээс 4.006.0 сая төгрөгийн төслийн материал цахимаар хүлээн авч баримт бичгийн бүрдлийн хүрээнд I, II шатны шалгаруулалтыг цахимаар, аймгийн Засаг даргын 2022 оны А/469 захирамжаар батлагдсан төсөл сонгон шалгаруулах Дэд хорооны хурлаар III шатны шалгаруулалтыг зохион байгуулж, 7 аж ахуйн нэгж, хоршоо шалгарч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүллээ.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт ажлын хүрээнд: Худалдаа, үйлчилгээний бүтээгдэхүүний тохирлын үнэлгээнд Аргалант, Баянхангай, Баянчандмань Лүн, Сэргэлэн, Зуунмод, Эрдэнэсант сумын 66 аж ахуйн нэгж, иргэний худалдаа үйлчилгээний цэгийг үйл ажиллагааг үнэлгээнд хамруулж, тохирлын гэрчилгээ 1-2 жилийн хугацаатай олголоо.

Хэмжилзүйн лаборатори: Аргалант, Баянхангай, Батсүмбэр, Баянчандмань Жаргалант, Угтаалцайдам, Зуунмод сумын үр тариа тээвэрлэлт, олборлолтын автомашины жин, худалдаа үйлчилгээний цэгийн жин, туухай нийт 108 ш массын хэмжих хэрэгслийг баталгаажууллаа. Дэлхийн стандартын өдөр, Дэлхийн чанарын өдөр арга хэмжээний хүрээнд

“Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг “Илүү сайхан дэлхийн төлөө хамтын зорилго” уриатай Эрдэнэсант суманд зохион байгуулж, 50 гаруй иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулж, сургалт мэдээллийн үйлчилгээ үзүүлээ.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Орчны бохирдолын талаар: Орчны бохирдлыг бууруурах үндэсний хорооноос зохион байгуулсан “Яндангаа хөөлье-Өнтэй өвөлжье” сарын аяны хүрээнд аймгийн хэмжээнд 2200 орчим өрх ханан пийшингээ хөөлөн, 1500 орчим иргэд, 3000 гаруй тээврийн хэрэгслийн жолооч нарт гарын авлага тарааж, мэдээллээр хангах нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд БОАЖСайд, аймгийн Засаг даргын 2022 оны 10 сарын 17-ны өдрийн А/425, А/585 дугаар хамтарсан тушаалаар “Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журмыг батлалаа.

Усыг хамгаалах, зүй зохистой ашиглах ажлын хүрээнд: Ус хангамжийн эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй хөнөөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зуунмод, Сэргэлэн сумдын ундны усны эх үүсвэрт аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022.10.13-ны өдрийн А/583 захирамжаар баталсан. Тус захирамжаар томилогдсон ажлын хэсэг удирдамжийн дагуу аймгийн төвийн цэвэр усны шинэ нөөцийн сан, Сэргэлэн сум, Хөшгийн хөндий дэх ус хангамжийн эх үүсвэрүүдэд газар дээр нь очиж эрсдлийн үнэлгээ хийлээ. Ажлын хэсэг 4 үндсэн чиглэлийн хүрээнд 15 бүлэг асуумжийн дагуу эрсдлийг үнэлж, Төв аймгийн төв Зуунмод сум, Сэргэлэн суманд байрлах ундны усны эх үүсвэрт аюулгүй байдлын эрсдлийг “Маш өндөр эрсдэлтэй” гэж дүгнэн, цаашид авах арга хэмжээг тодорхойлон, зөвлөмжийг боловсруулж байна.

Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 30 сая төгрөгийн зардлаар Алтанбулаг, Батсүмбэр, Жаргалант сумдын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн 3 худагт ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг худалдан авах ажиллагаагаар шалгарсан “Вотер филтер” ХХК гүйцэтгэсэн. Тус ажлыг аймгийн Засаг даргын 2022.09.27-ны А/550 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2022. 10.28-30 өдрүүдэд сумдад ажиллан ашиглалтанд хүлээн авлаа.

Уул уурхай, хяналт шалгалтын хүрээнд: Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан нөхөн сэргээлтийг хүлээж авах хамтарсан ажлын хэсэг Заамар сумын нутагт ажиллалаа. Тус сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөшөөрөлтэй 22 аж ахуйн нэгжийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт болон тухайн жилд хийгдсэн техник, биологи, дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн явцтай танилцаж, хэмжилт хийн хүлээн авч илэрсэн зөрчил дутагдлыг тайлангийн өмнө арилгуулахаар хугацаат үүрэг чиглэл өгч ажиллав. Урьдчилсан байдлаар Техникийн нөхөн сэргээлт -186.5 орчим га, Биологийн нөхөн сэргээлт -210 орчим га, Дүйцүүлэн хамгаалахаар -187.7 орчим га стандарт шаардлага хангасан нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хэмжилт хийн хүлээж авлаа.

Аялал жуулчлалын чиглэлээр: Тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилгоор Төв аймгийн БОАЖГ, Музейн захиргаа, Монгол туургатан театрын захиргаатай хамтран Богдхан уулын дархан цаазат газрын Манзуширын амны үзэсгэлэнт байгальд Монгол туургатан театрын “Шившлэгтэй зургийн нууц” хүүхдийн жүжгийг тоглож, “Манзушир арт” ардын урлагийн тоглолтыг жуулчдад зориулсан танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээг 1000 гаруй хүүхэд үзэж сонирхлоо. Зүүн өмнөд Азийн аялал жуулчлалын нэгдэлийн арга хэмжээ 10.25-10.27ны хооронд Вьетнам улсын Гуань-Нинь мужид зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд төрийн бус байгууллагыг төлөөлж аймгийн Аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд оролцсон. Форумын үеэр Аймгийн аялал жуулчлалын холбоо EATOF-ын гишүүн муж улсуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллалаа.

Ойн бодлогын хүрээнд: 2022 оны 10 дугаар сарын 12 нд Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн хүрээнд намрын мод тарилтын нээлт Зуун мод хотын төв талбайд хийлээ. Зуун модны хэмжээнд 28 ААНБайгууллага, 711 иргэн албан хаагч, 7 төрлийн 6645 ширхэг мод бут сөөг тарьж, 20,464,000 төгрөг царцуулсан байна. Аймгийн хэмжээнд 26 сум 9 дүгээр сарын 24 нөөс 10 дугаар сарын 16 ны хооронд намрын мод тарилтын нээлтүүд хийж, одоогоор 12 төрлийн 238000 мод бут сөөг таригдсан байна.

Аймгийн Засаг даргын 10 сарын 12-ны А/580 тоот захирамжын дагуу 10 дугаар сарын 17 ноос ой бүхий сумдаар ойжуулалат хүлээж авах ажилаар ажлын хэсэг ажиллаж байна.

Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Баянцогт сумдад 65%-85% тай 65 га ойжуулалт хүлээж аваад байна.

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭ

Урьдчилан мэдээлэх: Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм, энэ сарын 14, 22, 23-ний өдрүүдэд цас орж, зарим газраар цасан шуурга шуурч, салхи шуургатай байхыг анхааруулах мэдээг 3 удаа гаргаж, И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна.

Байгаль орчны шинжилгээний лаборатори: Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 48 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн багаж эвдэрсэн тул хэмжилт хийгдэхгүй байгаа азотын давхар ислийн дундаж агууламж 0.015 мг/м^3 үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад азотын давхар ислийн дундаж агууламж 0.002 мг/м^3 -ээр буурсан үзүүлэлттэй байна. Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 10 дугаар сард Туул-Лүн, Шивэрт-Борнуур, Хэрлэн-Мөнгөнморьт голуудын хяналт шинжилгээг хийхэд цахилгаан дамжуулах чанар нь Туул-Лүн 208 uS/cm , Шивэрт-Борнуур 509 uS/cm , Хэрлэн-Мөнгөнморьт 64.1 uS/cm тус тус гарлаа.

Ус судлалын салбар: Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2022 оны 10 дугаар сарын 21-ний байдлаар усны түвшин: Хэрлэн гол Хэрлэн-Хонгон 140 см , Хэрлэн-Мөнгөнморьт 102 см , Туул гол Туул-Алтанбулаг харуулд 547 см , Туул-Лүн харуулд 136 см , Туул-Заамар харуулд- 194 см , Сөгнөгөр-Сөгнөгөр 190 см , Шивэрт-Борнуур 154 см тус тус байсан ба өмнөх оныхтой харьцуулахад усны түвшин Хэрлэн голын дагуух Хэрлэн-Хонгон, Хэрлэн-Мөнгөнморьт харуулууд $4-12 \text{ см}$ бага, Туул голын дагуух Туул-Алтанбулаг, Туул-Лүн харуул, Туул-Заамар харуулууд $4-18 \text{ см}$ бага, Сөгнөгөр голын дагуух Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 15 см бага, Шивэрт голын дагуух Шивэрт-Борнуур харуул 16 см их байна. Хэрлэн, Туул голууд мөсөн зах, Сөгнөгөр, Шивэрт голууд харз үүсэж байгаа тул аж ахуйн нэгж байгууллага, ард иргэд голын гарам, гарцаар гарч байхыг онцгойлон анхааруулж байна.

ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Иргэн бүрийг “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо”-д хамруулах үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр ханган ажиллах аймгийн ажлын хэсгийн гишүүдэд ажил эрчимжүүлэх тухай чиглэл хүргүүлсэн. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн тоо 2022 оны 10 дугаар сарын 20-ны байдлаар 20093 иргэн хамрагдсан. 21 аймгийн хэмжээнд хамралтын хувиар нэгдүгээрт эрэмбэлэгдэж байна.

“Тогтвортой хөгжлийн зорилт-Эх, нярай, нөхөн үржихүйн эрүүл мэнд” аймгийн зөвлөгөөнийг ЭМГ-тай хамтран зохион байгууллаа. Монгол Улсад хэрэгжиж буй НҮБ-ын Хүн амын сангийн “Эх, нярайн тусламжид зайн оношилгооны дэмжлэг үзүүлэх” төслийн санхүүжилтээр “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх нярайн яаралтай тусламж” сэдэвт 2 өдрийн сургалт, арга хэмжээг хамтран зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээнд Улсын их хурлын гишүүн П.Анужин, Б.Жаргалмаа, Ц.Туваан, ЭМЯамны төлөөллүүд, ЭМДЕГ-ын дарга Л.Бямбасүрэн, ЭМБ-ын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон.

Аймгийн Нэгдсэн төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, хэрэгжилтийн явцыг хэлэлцүүлэх “Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд”, Хавдрын эсрэг “Эрүүл Төв аймаг” хөтөлбөрүүдийн тайланг хянаж, дүгнэлт авахаар ХШҮХ-т хүргүүлсэн. Олон улсын багш нарын 28, Монгол Улсын багш нарын 56 дахь баярын өдөр болон Монгол Улсад боловсролын салбар үүсч хөгжсөний 101 дэх жилийн ойг тохиолдуулан “Шинэ үеийн боловсрол-Залуу үеийнхэн” сургалт зөвлөгөөн, багш нарын баярын бага хүрлыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран зохион байгуулав.

Италийн АЙФО төрийн бус байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжил оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн 70 толгой ямааг 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Баян сумаас Баяндэлгэр суманд шилжүүллээ.

Харьяа байгууллагуудын төрийн жинхэнэ албан хаагчдыг жендэрийн 3 төрөлт модуль сургалтад хамруулах ажлыг эрчимжүүлж ажиллаж байна.

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Эмнэлгийн тусламж үйлчилгээ:

Аймгийн хэмжээнд 2022 оны 9 дүгээр сарын байдлаар 581 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 287 тохиолдлоор буурсан ба 589 нярай бүртгэгдсэн байна. Жирэмсний хяналтад нийт 754 эмэгтэй байна, 942 жирэмсэн эмэгтэйд шинээр хяналтад авснаас эхний 3 сартай хяналтад 92.72% хамрагдсан. Нийт 246418 хүнд үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 89324, амбулаторийн үзлэг 128010, идэвхтэй хяналтын 19577 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 12934 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 25.06%, осол гэмтлийн дуудлага 2.8%-ийг эзэлж байна. Стационарт 12803 хүн эмчлэгдэн нийт 93916 ор хоног ашигласан байна. Дундаж ор хоног 7,3 байна.

2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Коронавируст халдвар /Ковид-19/-тай 42 иргэн эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдсанаас, 37 иргэн эмчлэгдсэн, нас баралт-0, одоогоор 5 иргэн эмчилгээнд хамрагдаж байна. ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн тусалж, илэрсэн зөрчил, дутагдлыг танилцуулан, ажил эрчимжүүлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн.

Алтанбулаг сумын ЭМТөв, “Эх булаг сувилал”-д магадлан итгэмжлэлд бэлтгэх, дэмжлэгт хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөн туслах баг ажиллан, газар дээр нь болон цахимаар магадлан итгэмжлэлд хамруулсан.

“Ахмад настны эрүүл мэндийг дэмжих сарын аян”-ыг зохион байгуулах төлөвлөгөөг салбарын хэмжээнд боловсруулан батлуулж, хэрэгжилтийн тайланг ЭМБ-аас авч нэгтгэн хүргүүлсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хавдар, сэтгэцийн эрүүл мэндийн кабинет, Өрхийн эрүүл мэндийн төв, Борнуур, Батсүмбэр сумдад мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн индексжүүлсэн 830 жорыг баримтжуулан олгосон.

Эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт, уулзалт, зөвлөгөөн:

“Тогтвортой хөгжлийн зорилт-Эх, нярай, нөхөн үржихүйн эрүүл мэнд” аймгийн зөвлөгөөн зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд эрдэмтэн докторууд, аймгийн удирдлагууд, төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа явуулж буй эмнэлгийн нийт 100 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцон, эх, нярай, нөхөн үржихүйн чиглэлээр салбарт тулгамдаж байгаа асуудлуудаа тодорхойлж, цаашид шийдэх арга замыг хэлэлцүүлэн, нэгдсэн зөвлөмж гарган, салбарын алба хаагчид болон сумдад хүргүүлсэн.

Монгол Улсад хэрэгжиж буй НҮБ-ын Хүн амын сангийн “Эх, нярайн тусламжид зайн оношилгооны дэмжлэг үзүүлэх” төслийн санхүүжилтээр “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх нярайн яаралтай тусламж” сэдэвт 2 өдрийн сургалт зохион байгуулагдан, анхан болон лавлагаа шатлалын ЭМБ-ын нийт 65 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцлоо.

Эм, эмнэлгийн хэрэгсэл хяналт зохицуулалтын газраас зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, ерөнхий гэрээгээр эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах” сэдэвт 21 аймгийн тендер хариуцсан мэргэжилтнүүдийн чадавх сайжруулах сургалтад хамрагдсан. Удирдлагын академиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчлэл” сургалтад 3 албан хаагч хамрагдсан. Ажлын байран дээр дадлагажуулах, сургах ажлын хүрээнд Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт Заамар сумын Эрүүл мэндийн төвийн эх баригч 14 хоногийн ажлын байрны дадлага сургалтад хамрагдсан.

ЭМХТ, АНЭ-тэй хамтран “Лабораторийн тусламж, лаборант нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх” сэдэвт лаборант нарт зориулсан 2 өдрийн онол, дадлага хосолсон чадавхжуулах сургалт зохион байгуулан, АНЭ, сум, өрхийн ЭМТ-ийн 50 лаборантийг хамрууллаа.

Төв аймагт эм хангамжийн салбар үүсч хөгжсөний түүхт 80 жилийн ойн арга хэмжээг “Монгол эм импекс концерн”-ХХК, “Эм зүйн байгууллагуудын нэгдсэн эм холбоо” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, хурал, чадавхжуулах сургалтад нийт 56 эм зүйн салбарын мэргэжилтнүүд хамрагдлаа. ДЭМБ-ын Төслийн хүрээнд АНЭ, 27 сум, өрхийн ЭМТ-ийн нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад “Нийгмийн эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах” 2 өдрийн сургалт НЭМҮТ-тэй хамтран зохион байгуулж, 42 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамрууллаа. АШУҮИС-ийн 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Клиникийн профессор цол 2 эмч хүртлээ. Эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах 8 удаагийн сургалт, уулзалт, зөвлөгөөнд 298 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.

Иргэдэд зориулсан мэдээлэл сургалт сурталчилгаа:

"Олон Улсын охидын өдөр"-ийг тохиолдуулан "LISTEN TO FLOWERS" өдөрлөгийн хүрээнд Зуунмод сумын ЕБС-иуд, Политехник коллежийн нийт 300 охидод өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулан, мэдлэг хандлагыг дээшлүүллээ.

"Оролцоод манлайлъя" хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын чуулганд оролцож, Стресс ба эерэг хандлага сэдвээр сургалт зохион байгуулан, зорилтот бүлгийн хүүхэд, залуучууд болон тэдний асран хамгаалагч нар 60 хүнийг хамрууллаа. Төв аймгийн Цагдаагийн газрын 160 алба хаагчдад "Архины хэрэглээ" сэдвээр сургалт зохион байгуулж, архи согтууруулах ундааны зохистой хэрэглээ, хор уршгийн талаар мэдээлэл өглөө.

Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 28 багш ажилчдаас бие бялдрын түвшин тогтоох сорил авч, эрүүл зөв хооллох, дасгал хөдөлгөөн хийх зөвлөгөө мэдээлэл өгсөн.

ЗӨСҮТ-тэй хамтран зоонозын халдвараас урьдчилан сэргийлэх, чадавхыг сайжруулах чиглэлээр ЦГ, АНЭ, ОБГ, БОАЖГ, МЭГ-ын нийт 32 албан хаагчдад сургалт зохион байгуулан, чадавхжуулсан. АШУҮИС-ийн уушги, харшил судлалын тэнхимтэй хамтран "Харшил, түүнийг үүсгэх шалтгаан, урьдчилан сэргийлэх арга зам, орчны эрүүл мэндийн нөлөөлөл" сэдвээр иргэдэд зориулсан сургалт зохион байгуулж, Зуунмод сумын төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан албан хаагчид, 6 багийн иргэд нийт 150 гаруй хүнийг хамруулсан.

НҮБ-ын Хүн амын сан, Эрүүл мэндийн яам, Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс хамтран зохион байгуулсан "Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нь" сэдэвт сургалтад аймгийн Нэгдсэн эмнэлгийн 25 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцлоо.

АНЭ Дэлхийн зүрхний өдрийн хүрээнд нийт 4368 хүний артерийн даралт хэмжиж, боршур, 100 зүрх хэвлэж иргэд болон эмч, эмнэлгийн ажилчдад энгэрийн тэмдэг тараасан. Төв аймаг дахь Хаан банк, Төрийн банк, Хас банк, Төв Чандмань Дулааны эрчим хүчний газар, Төрийн Үйлчилгээний нэгдсэн төв, Зуунмод сумын ЗДТГ, Замын цагдаагийн хэсэг, ХХҮГ зэрэг 8 албан байгууллагыг даралтын аппаратаар хангасан. Зүрх судасны нарийн мэргэжлийн эмч аймгийн ТБС телевизээр олон нийтэд мэдээлэл өгч сурталчиллаа.

Иргэдэд зориулсан 8 удаагийн сургалт, сурталчилгаанд нийт 5100 гаруй иргэдийг хамруулсан.

Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт:

Улсын төсвийн 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар сум, өрхийн ЭМТ-д 16 нэр төрлийн 528 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж, АНЭ-т 236.5 сая төгрөгийн мэс заслын CRM аппарат, нүдний мэс заслын микроскоп нийлүүлсэн.

ЭМЯ-ны 409,9 төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 25 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл хамгаалах хувцас хэрэгсэл, оношлуурыг Нэгдсэн эмнэлэг, Баруун-Зуунмод өрхийн эрүүл мэндийн төв, 26 сумын Эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн газрын даргын А/52 тоот тушаалаар хуваарилан олгосон.

Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр тэтгэмж, урамшуулал авах эрх нь үүссэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд нийт 111,584,152 төгрөг олгохоор шийдвэрлэсэн.

Эрүүл мэндийн салбарын нийт 28 байгууллагын 2022 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. НҮБ-ын хүүхдийн сангийн төслийн хүрээнд 15 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЭМГ-ын дэргэд стандартад нийцсэн вакцины агуулахын өрөө, ДЗОУБТОНХХ-ийн 25 сая төгрөгийн дэмжлэгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм сэтгэлзүй, сэргээн засах чиглэлээр "Аз жаргалтай төв"-ийг тохижуулан, засварлаж ашиглалтад оруулсан.

Эрүүл мэндийн яамны 11,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аюулгүй ажиллагааны хайрцаг, тог тогтворжуулагчийг татан авч, ЭМГ-ын даргын А/53 дугаар тушаалаар дархлаажуулалтын нэгжүүдэд хуваарилан олгосон.

Халдварын сэргийлэлт хяналт:

Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тогооч ажилчдын үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор үдийн цай, хоол үйлдвэрлэлийн хэсэг, анги танхимын орчны эрүүл ахуй халдвар хамгааллын нөхцөлд орчны эрүүл мэндийн лабораторид суурилсан тандалтыг зохион байгуулан, агаар, хөрс, арчдас шинжилгээг авсан, хариу хүлээгдэж байна.

Орчны эрүүл мэндийн лабораторид нийт 510 сорьцод хими нян судлалын шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Химийн лабораторид унд ахуйн усны 21 усанд 336 үзүүлэлтээр, нян судлалын лабораторид нийт 489 сорьцод 594 үзүүлэлтээр, эмнэлгийн дотоод халдвар ариун чанарын 9 сорьцод 9 үзүүлэлтээр шинжилгээ хийгдлээ.

Аймгийн хэмжээнд 10 дугаар сард Коронавируст халдвар (Covid-19)-ын 20 батлагдсан тохиолдол, үүнээс Зуунмод сумын 14 батлагдсан тохиолдолд, мөн тууралтад болон гэдэсний халдварын 17 тохиолдолд тандалт судалгаа хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсэн.

Лүн сумын цагдаагийн постод хураагдсан тарваган тахлын сэжигтэй материал болох 180 ширхэг тарвагыг ЗӨСҮТ-д хүлээлгэн өгч, голомтын халдваргүйтгэл хийж, тээвэрлэсэн иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Зуунмод хотын 6 багийн иргэдийн нийтийн хуралд оролцож, стандартын шаардлага хангасан нүхэн жорлон, ил задгай хог хаягдал хаяхгүй байх уриалга, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 2600 ширхэг гарын авлага материалыг иргэдэд түгээж, мэдлэг, хандлагыг дээшлүүлсэн.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны өдрийн А/505 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын мэдээг Эрүүл мэндийн газар сар бүр тогтмол төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас авч нэгтгэн хяналтан тавин ажиллаж байна.

ХОЁР. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал 2022 оны 09 дүгээр сарын 29-ний 15:00 цагт БШУГ-т зохион байгуулагдлаа. Зөвлөлийн хурлаар Зуунмод сумын боловсрол болон хөгжлийн үйлчилгээнд хамрагддаггүй хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхдийг оролцуулж, боловсролын үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах шийдвэрийг зөвлөлөөс гаргалаа. Хуралд хөндлөнгийн ажиглагчаар “JICA” ОУБ-ын Старт-2 төслийн тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтэн Үэхара Шооко, төслийн зохицуулагч Г.Норжмаа нар оролцлоо.



Олон улсын багш нарын 28, Монгол Улсын багш нарын 56 дахь баярын өдөр болон Монгол Улсад боловсролын салбар үүсч хөгжсөний 101 дэх жилийн ойг тохиолдуулан “Шинэ үеийн боловсрол-Залуу үеийнхэн” сургалт зөвлөгөөн, багш нарын баярын бага хүрлэг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр амжилттай зохион байгуулав. Төв аймгийн ЕБС, цэцэрлэгийн төлөөлөл болох 120 залуу багш нарт сургалт зохион байгуулж, Зуунмод сумын 4 дүгээр сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцож, Монгол Улсын гавьяат багш нарт хүндэтгэл үзүүлж, боловсролын салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтан албан хаагчдыг шагнаж урамшуулав.


Боловсрол шинжлэх ухааны яамнаас санаачлан хэрэгжүүлж буй Мон-Х (иргэдийн инновацийн санаачилгыг дэмжих) хөтөлбөрийн сургалт хэлэлцүүлгийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр БШУГ, Мон-Х төслийн багтай хамтран зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлэгт 13 байгууллагын төлөөлөл оролцож, орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй асуудлыг салбарын хэмжээнд тодорхойлж, асуудлыг инновацийн оролцоотой хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцлоо.

2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Төв аймагт ОХУ-ын Томскийн Их сургуулийн танилцуулга уулзалт Солонго цогцолборт амжилттай боллоо. Энэхүү танилцуулга уулзалтыг ОХУ-ын Томскийн Их сургууль, Төв аймгийн БШУГ болон РЦНК-ийн Төв аймаг дахь салбар төв хамтран зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд Зуунмод сумын 12 дугаар ангийн 180 суралцагч оролцлоо.



2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Зуунмод сумын 4 дүгээр сургууль дээр Томскийн Политехникийн их сургуулийн танилцуулга уулзалт боллоо. Тус танилцуулга уулзалт нь 20 сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад цахимаар танилцуулагдлаа. Энэхүү уулзалтад 503 суралцагч хамрагдаж мэдээлэл авлаа. Мөн Владивостокийн улсын их сургууль Зуунмод сумын 3 сургууль дээр танилцуулга уулзалтыг зохион байгууллаа.

МУ-ын Хөдөлмөрийн баатар, МУГТ, Дархан аварга Ж.Мөнхбат аваргын нэрэмжит Төв аймгийн аварга шалгаруулах 48 дахь удаагийн тэмцээн Төв аймгийн Зуунмод суманд амжилттай зохион байгуулагдаж байна. Тэмцээнд 12 сум, төвийн 3 сургуулийн өсвөр үеийн 96 тамирчин оролцож, Тэмцээнийг Төв аймгийн БТСГ, БШУГ, Хакухо сан, аваргын гэр бүл хамтран зохион байгууллаа.



Боловсрол, шинжлэх ухааны газраас 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Барилга захиалагч орон сууцны корпорацтай хамтран Өвсний үндэс хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Хүмүүн цогцолбор дунд сургуулийн их засварын ажлын гүйцэтгэлтэй очиж танилцлаа. Шинэчлэл Инвест ХХК нь 2022.08.16-ны өдрөөс эхлэн 2022.12.10-ны өдөр бүрэн ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан ба барилгыг шинэчлэн засварлах ажлын гүйцэтгэлийн явц 80%-тай явагдаж байна.

Боловсрол шинжлэх ухааны газрын алба хаагчид ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын чиглэлээр 45 ширхэг хайлаасыг тарьялаа. “Анги удирдсан багшаар дамжуулж эцэг эхийн боловсролыг дэмжих арга зүй” сургалтын 2 дугаар шат буюу орон нутгийн 2 өдрийн сургалт Төв аймагт зохион байгуулагдлаа. Сургалтад Төв аймгийн ерөнхий боловсролын төрийн өмчийн 32 сургууль, төрийн бус 1 сургууль, Политехникийн 2 коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн 2 төвийн багш, нийгмийн ажилтнууд хамрагдлаа. Сургалтад урилгаар Монголын нийгмийн ажилтнуудын нийгэмлэгийн тэргүүн Б.Мөнхжаргал, ГБХЗХГ-ийн сургалт судалгаа мэдээллийн төвийн захирал Г.Ариунчимэг нар оролцож, нийгмийн ажилтан, багш нарт эцэг эхтэй харилцах арга зүйн зөвлөгөө мэдээлэл болон хүүхэд хамгаалал, эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагаа чиглэлээр сургалт мэдээлэл өглөө.

Говьсүмбэр аймагт болсон Орос хэлний олимпиадад амжилттай оролцож Багшийн олимпиадад Баянчандмань сумын орос хэлний багш Б.Туяацэцэг 1-р байр, ОХУ-д мэргэжил дээшлүүлэх сургалтад 100% тэтгэлгээр мэргэжил дээшлүүлэх эрх, Хүмүүн Цогцолбор сургуулийн 126 ангийн сурагч Н. Маралгоо, 12е ангийн сурагч Номин-Эрдэнэ нар ОХУ-ын их дээд сургуульд 100% тэтгэлгээр суралцах эрхээр шагнагдлаа. Орос дууны төрөлд ХЦС-ийн 11 дүгээр ангийн сурагч Б.Баярчимэг 2-р байр, ХЦС-ийн 12 дугаар ангийн сурагч Халиунаа, орос шүлгийн тэмцээнд 1-р байр, Баянчандмань сумын ЕБС-ийн сурагч Жаргалсайхан тусгай байрын шагнал тус тус эзэллээ.

Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар Эрдэнэт үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар Төв аймгийн Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр нийт 2 барилгын ариун цэврийн байгууламж, Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг багийн сургууль, цэцэрлэг, Загдал багийн сургууль нийт 3 барилгын ариун цэврийн байгууламжийг “Баатар шүтээн уул” ХХК хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өглөө.

Боловсролын чанарын үнэлгээг зохион байгууллаа. Боловсролын чанарын үнэлгээний зорилго нь бага, дунд боловсролын чанарыг системийн түвшинд үнэлж, суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага, түүнийгээ амьдрал ахуй, практикт асуудлыг шийдвэрлэхэд хэрхэн хэрэглэж буй байдлыг үнэлж хэмжээсжүүлэх, боловсролын чанарт нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлоход чиглэгдэж байна. Тус үнэлгээг бага, суурь, бүрэн дунд, мэргэжлийн боловсролын түвшинд түүврийн аргаар зохион байгуулж буй бөгөөд аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 3 сургууль, МБСБ-ын 2 сургуулийн 6, 10, 12-р ангийн нийт 580 суралцагч хамрагдсан.

Багш нарын спортын наадмыг 2022 оны 10 дугаар сарын 21, 22-ны өдөр Төв аймгийн Эрдэнэ суманд 5 төрлөөр зохион байгуулж 200 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдлөө. Уг тэмцээнээс шалгарсан тамирчид Өвөрхангай аймагт зохион байгуулагдах “Хөдөөгийн багш нарын спортын XIX наадамд” оролцох эрхээ авлаа.



ГУРАВ. ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ

2022 оны 10 дугаар сарын байдлаар 1915 иргэнд 5115.7 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1258 иргэнд 1034.2 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1077 иргэнд 794.2 сая төгрөгийн амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, 33 иргэнд 39.6 сая төгрөгийн онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж, 9702 эхэд 1249,3 сая төгрөгийн “Алдарт эх” 1, 2-р зэргийн одонтой эхийн мөнгөн тэтгэмж, 5763 ахмад настанд 916.9 сая төгрөгийн насны хишиг тэтгэмж, 2480 ахмад настанд 437.6 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 975 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 149.9 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 5438 иргэнд 502.0 сая төгрөг, жирэмсэн 1503 эхэд 232.2 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 6643 эхэд 1926.9 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 324 эх /эцэг/-т 381.2 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 23 ихэр хүүхдэд 46,0 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 4 иргэнд 6,9 сая

төгрөг, 34089 хүүхдэд 33872.9 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 125 иргэнд 5,1 сая төгрөгийг тус тус олгосон.

Нийгмийн хөгжлийн чиглэлээр:

Аймгийн Ахмадын хорооны 138,4м² талбай бүхий 6 өрөөг Холт Интернэйшнл ОУБ-ын санхүүжилтээр тохижуулан засварлаж "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв" болгон ашиглах, барилгатай холбоотой нэмэлт мэдээлэл, урсгал засварын нарийвчилсан тооцоолол, төсвийг гаргаж хөтөлбөрийн захиралд албан бичгээр баталгаажуулан хүргүүлсэн. Мөн тус төвийг ажиллуулах 2 албан хаагчтай холбоотой цалин хөлс, урсгал зардлын төсвийг 2023 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар саналыг хүргүүлсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 975 өрхийн 2661 иргэн, 2777 хүүхдэд 502,4 сая төгрөгийн 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн олгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлж ажилласан. Үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хөдөлмөр эрхлээгүй 25 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулж 1 иргэнийг түр ажлын байранд зуучилсан.

Зуунмод сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авагч 227 өрхөд дотоод хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтаар өрхийн амьжиргаанд өөрчлөлт орсон эсэх хөдөлмөрийн насны иргэд журмын хэрэгжилт хангасан эсэх тайлбарыг сумын амьжиргааг дэмжих зөвлөлд нэгтгэж хүргүүлсэн.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан:

Шинээр бий болсон 159 /нийт 859/-н шинэ ажлын байрыг бүртгэн мэдээллийн санд оруулсан. Сул чөлөөтэй ажлын байранд ажил хайгчаар бүртгүүлсэн 77 иргэнийг зуучилж /нийт 522/ иргэн ажилд зуучлагдлаа. Түр ажлын байранд ажилласан 2353 /нийт 8530/ иргэнийг бүртгэж мэдээллийн санг үүсгэн ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Старт апп арга хэмжээний бүртгэлийг зарлан нийт 13 багийн 28 иргэн бүртгүүлснээр бизнес санааг хөгжүүлэх 3 хоногийн сургалтад 9 баг оролцлоо. Сургалтын хугацаанд 4 баг өөрийн хүсэлтээр сургалтаас гарч эхний шатны шалгаруулалтад Батсүмбэр, Баянцагаан, Зуунмод сумдын 5 баг оролцсон. Тус арга хэмжээг сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр дээрх 5 багийг хурдасгуур хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэн сургалтыг эхлүүлсэн.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг "Сонор Эдүкейшн" сургалтын төвтэй хамтран Зуунмод сумын Хүмүүн цогцолбор, 4, 5-р сургуулийн 9, 10, 11 дүгээр ангийн 376 суралцагчид бүлгээр зохион байгуулсан.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтыг Батсүмбэр сумын Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн хөдөлмөрийн насны 20 иргэнд зохион байгууллаа.

Бусад:

"Нийгмийн түншлэлийн сүлжээ"-ТББ-тай хамтран ХЭДСанд хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж Хөтөлбөрт хамрагдсан болон хамрагдаагүй 8 иргэнтэй бүлгийн ярилцлага, Багийн Засаг дарга, хэсгийн ахлагч, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүдийг оролцуулсан 11 албан хаагч оролцсон бүлгийн ярилцлагыг хамтран зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:

Тайлант хугацаанд 33 иргэний 58207,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт ХЭДСанд төвлөрч, өссөн дүнгээр 660 иргэний 518316,1 мянган төгрөг төвлөрсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрт тухайн сард 6 иргэний 19152,0 мянган төгрөг төлөгдөж өссөн дүнгээр 25 иргэний 114616,1 мянган төгрөг ХЭДСанд төвлөрсөн байна.

ХЭДСанд 1741050,0 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн бөгөөд тайлант сард 1069273,5 мянган төгрөгийг зарцуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн төслийг шалгаруулах аймаг, сумын хамтарсан ажлын хэсгийн нэгдсэн хуралдаанаас 20 иргэнд 118,0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэгдсэн.

Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт Баян-өнжүүл, Борнуур, Зуунмод, Дэлгэрхаан, Жаргалант, Өндөрширээт, сумын 10 иргэний төслүүд шалгарсан ч 95,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 10 шинэ ажлын байр бий болсон. Мөн малжуулах арга хэмжээний хүрээнд Баян-Өнжүүл, Баянцагаан сумын 3 малчин өрхийг хамруулан 15,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож 109 толгой малаар малжууллаа.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Зуунмод, Борнуур, Дэлгэрхаан сумын хувиараа хөдөлмөр эрхлэгч 6 ахмадын төсөлд 30,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, тэдгээрийн ажлын байрыг ажилгүйдэлд өртөхөөс сэргийлж хадгаллаа.

ХБИХЭД хөтөлбөрийн хүрээнд Зуунмод, Дэлгэрхаан, Жаргалант сумын 3 иргэн төслийн хуралд оролцож, шалгарсан 3 иргэний төсөлд 19,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмжөө сайжруулах боломжийг олгож, 3 иргэний ажлын байр шинээр бий болсон.

Ногоон ажлын байр хөтөлбөрийн хүрээнд Баянчандмань, Баян-Өнжүүл, Батсүмбэр сумдад 30 иргэн, НХАжлыг Баянчандмань, Баянөнжүүл, Өндөрширээт, Батсүмбэр, Баяндэлгэр, Эрдэнэсант сумдад эхлүүлэн 60 иргэний түр ажлын байр гарган орон нутаг бүтээн байгуулалтын ажилд ажиллуулж байна.

ГУРАВ. ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР

Хүүхэд хөгжил, хамгааллын хүрээнд:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний нөхцөл байдалтай танилцах, тандалт судалгаа хийж, орон нутаг дахь хөгжлийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор манай аймагт ажлын хэсэг ажилласан. Тус ажлын хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа сургалтын байгууллагуудын төлөөлөл, эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн төлөөлөл, оролцооны байгууллагын сурагчдын төлөөллүүдтэй уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулан, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэд үйл ажиллагаа явуулдаг дугуйлан, хүүхэд хөгжлийн ордны үйл ажиллагаатай танилцсан.

"Олон Улсын Охидын өдөр"-ийг тохиолдуулан Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн Төв аймаг дахь салбар, кино шүүмжлэгч, өргө.мн сэтгүүлч О.Пагма, Төв аймгийн хүүхдийн зөвлөл хамтран "LISTEN TO FLOWERS" өдөрлөгийг зохион байгуулж Зуунмод сумын Ерөнхий боловсролын сургууль, политехникийн 8-12-р ангийн 300 охид оролцсон.

- "Охидын ариун цэвэр" эрүүл мэндийн боловсрол

- "Сэтгэл гутралын ачаар дуртай мэргэжлээ олсон нь" мэдээлэл зөвлөгөө

- "Аюулгүй болзоо" мэдээлэл, зөвлөгөө

- "Make up" охидын арьс арчилгаа

- "Хэлэлцүүлэг, санал асуулга гэсэн сэдвийн хүрээнд өдөрлөг зохион байгуулагдсан.

"Олон Улсын Охидын өдөр"-ийг тохиолдуулан "LISTEN TO FLOWERS" өдөрлөгийн хүрээнд хүүхдүүдийн зурсан "Гэр бүл амгалан бол хүүхэд жаргалтай" зургийн үзэсгэлэнг Төв аймгийн УНТ-д 2022.10.11-12-ны өдрүүдэд нээлттэйгээр дэлгэж иргэдэд хүргэсэн.

Төв аймгийн Заамар сумын 1-р сургууль, Хайлааст багийн 2-р сургууль, Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль дээр "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ зохион байгуулсан. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний хүрээнд 8-12-р ангийн 994 сурагчдад "Үе тэнгийн дээрэлхэлт, цахим донтолт, гэмт хэрэг, зөрчлийн талаарх", "Мэргэжил сонголт", "Өсвөр насны нөхөн үржихүй", "Төлөвлөлтөд суралцах, Сонголт хийх эцсийн шийдвэр гаргах" зэрэг сургалт, өсвөрийн сэргийлэгч бүлгийн хүүхдүүдэд арга зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай 17 хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Хүүхдийн тусламжийн 108 тусгай утсаар ирсэн 16 дуудлага мэдээллийн дагуу хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлж 4 дуудлага хаагдаж 12 дуудлага мэдээллийг хяналтдаа авч хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж байна.

Гэр бүлийн чиглэлийн хүрээнд:

Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн "Шинэ сургуулийн жилийн нээлт"-ийн арга хэмжээний хүрээнд тус нэгтгэлийн нийт 36 офицер болон ахлагч бүрэлдэхүүнд 2022 оны 10



дугаар сарын 10-ны өдөр "Гэр бүлийн харилцаа ба эцэг, эхийн үүрэг хариуцлага" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Намрын дунд сарын шинийн 17-ны Балжинням, Дашнямтай билэгт сайн өдөр буюу 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Залуучуудын хөгжлийн төвөөс "Гэр бүлийн андгай өргөх, гэрлэлтийн гэрчилгээ гардуулах" ёслолын арга хэмжээнд 3 хосыг хамруулан зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Төв аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн албан хаагч, "Хамтарсан баг"-ийн гишүүдийг чадавхжуулах баруун бүсийн сургалтыг Лүн суманд зохион байгууллаа. Тус сургалтад Төв аймгийн Лүн, Эрдэнэсант, Өндөрширээт, Аргалант, Баянхангай, Заамар сумдын нийт 64 албан хаагч оролцлоо.

Долоо хоног бүрийн Баасан гарагийн 17:00 цагт "Гэр бүлийн боловсрол олгох цаг", "Сэтгэл зүйн эрүүл мэндээ хамгаалах 7 дүрэм", "Стресс тайлах 9 арга, Стресстэй тэмцэх стратеги", "Хосуудын зөвлөмж" зэрэг 3 сэдвээр мэдээлэл бэлтгэн байгууллагын цахим хаягт байршуулж, иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.

Залуучуудын хөгжлийн чиглэлийн хүрээнд:



АЙМГИЙН ЗАЛУУЧУУДЫН САЛБАР ЗӨВЛӨЛ БОЛОН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛҮҮДИЙН ХАМТАРСАН "ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ" боллоо. Уг арга хэмжээнд аймгийн Засаг дарга бөгөөд Залуучуудын САЛБАР зөвлөлийн дарга Д.Мөнхбаатар, аймгийн ЗДТГ-ын дарга М.Отгонбат, НБХ-ийн дарга Д.Мөнхцэцэг, Зуунмод сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч Ч.Сарангэрэл, ГБХЗХГ-ын залуучуудын хөгжлийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагва-Орлом болон аймгийн

Залуучуудын Хөгжлийн Зөвлөл (ЗХЗ), Байгууллагын дэргэдэх ЗХЗ, Зуунмод хотын ЗХЗ-ийн удирдлагууд оролцлоо. Мөн 27 сумын ЗХЗ-ийн удирдлагууд цахимаар холбогдож, мэдээлэл авлаа.



Залуучуудын хөгжлийг дэмжих сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, цахим номын сангийн өрөө тасалгааг тохижуулах, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж үйл ажиллагааг жигдрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Цахим номын сангийн үйл ажиллагааг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын танхимд нээн шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлдэн 7 компьютерыг бүрэн суурилуулан 120 сонсдог ном 150 гаруй PDF хувилбараар унших ном

суулган интернэтийн сүлжээг холбон ажиллахад шаардлагатай бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Шинэ цагийн илгээлтийн эзэд" аяны хүрээнд Төв аймгийн Цээл сумын ЕБС-ын ахлах ангийн сурагчид сайн дурын ажилд оролцлоо.Эцэг эхийн зөвшөөснөөр хүнсний ногоо хураах ажилд давхардсан тоогоор 228 сурагч 720 тн төмс хурааж, сумын ЗДТГ-ын 12 албан хаагчид хадлан тэжээл хураах ажилд 72 цагийг сайн дурын ажилд зарцуулсан байна.



Төв аймгийн ХБИргэдийн холбооны санаачилгаар ГБХЗХГ-ын Залуучуудын хөгжлийн төвөөс Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын чуулганыг амжилттай зохион байгуулж зорилтот бүлгийн хүүхэд, залуучууд болон тэдний асран хамгаалагч нарын 60 гаруй хүн оролцоо. Тус чуулганд ХХҮГ, ЭМГ, Дэлхийн зөн ОУБ, Тэмүүлэл хүмүүнлэгийн нэгдсэн холбооны Нийтэд үйлчлэх төвийн тэргүүн Ж.Мөрөндэлгэр, ХБХүүхдийн сэргээн засах төв хамтран ажиллаа.



2022.10.03-ны өдөр ГБХЗХГ газрын удирдлага, Завхан, Хөвсгөл, Хэнтий аймгийн ЗХТөвийн холбогдох мэргэжилтнүүд Налайх дүүрэг болон Төв аймгийн ГБХЗХГ, Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх уулзалт зохион байгууллаа.



Орон нутгийн иргэдэд харшил атопийн дерматит өвчнөөс сэргийлэх хяналтыг сайжруулах эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг Аймгийн ЭМГазраас санаачлан АШУҮИС, Залуучуудын хөгжлийн төв хамтран танхимаар болон цахимаар зохион байгуулж тус сургалтад 100 гаруй иргэд оролцлоо.

ГБХЗХГазраас “ЭРЭГ ХАНДЛАГА-ЭРҮҮЛ ОЮУТАН” УРИАТАЙ ОЮУТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САРЫН АЯН зарласантай холбоотойгоор олон нийтэд суртчилах, мэдээлэх зорилготой 7 удаагийн постер 1 бичлэг оруулан ажиллалаа. Хандалт 540+21 аймаг, 9 дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад Төв аймгийн ЗХТөвийн мэргэжилтэн, ажилтан нар хамрагдлаа.

Сургалтаар амьдрах ухааны сургалтын шинэчилсэн модулийн сургагч багш бэлтгэх сургалтын хүрээнд: Сайн дурын ажлын онцлог, Залуучуудын төвийн үйл ажиллагаагаар дамжуулан орчин үеийн хүүхэд, залууст эзэмшүүлэх шаардлагатай ур чадварууд, Сэтгэл мэдрэмжээ илэрхийлэх чадвар, Асуудал шийдвэрлэх ур чадвар, Бусдаас ялгарах онцлог, давуу талаа танин мэдэж, амьдралд хэрэгжүүлэх дасгал, Хүүхэд залууст зориулсан тоглоомоор дамжуулан сэтгэл засах хөтөлбөр, Мөн хүүхэд, залууст зориулсан тархи амрах майндфүлнэс хөтөлбөр, Шилжин суурьшигч залуустай ажиллахад анхаарах зүйлс, Залуу гэр бүл зориулсан хөтөлбөрийн хүрээнд гэр бүлийн уур амьсгалыг дэмжих, хүүхэдтэйгээ ажиллах дасгал, Хүүхэд хүмүүжлийн эерэг арга зэрэг сэдвүүдээр сургалтад хамрагдлаа.

ДӨРӨВ. СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн СУГ-аас СУИС-ийн Соёл урлагийн салбарын мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран соёлын төвийн удирдах ажилтнуудад зориулсан инноваци бүтээлч үйлдвэрлэл, соёл, чөлөөт цагийн технологи, найруулах ур чадвар, байгууллагын төлөвлөлт, санхүүгийн тооцоолол хийх аргачлал сургалтыг 4 хоногийн хугацаанд зохион байгууллаа.

Аймгийн ИТХ-ын 12 дугаар хуралдаанаар 7 сумын 25 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг болон орчны газрын солбицлын цэгийг хэлэлцүүлэн батлууллаа.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийн баг бүрэлдэхүүн батлагдсан 2,3 маршрутын дагуу Алтанбулаг, Аргалант, Баянхангай, Заамар, Угтаалцайдам, Цээл, Баян-Өнжүүл, Бүрэн, Баянцагаан, Дэлгэрхаан, Өндөрширээт, Эрдэнэсант, Лүн зэрэг сумдын 238 дурсгалт газрын тооллогын ажлыг амжилттай тоолж дууслаа.

Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Соёл урлагийн газрын албан хаагчид “Одонт” хөтөлд мод тарьялаа.

Монгол туургатан театрын уран бүтээлчид БНСУ-ын Чөжү хотод 61 дэх удаагийн Тамна олон улсын соёлын фестивалд 10 дугаар сарын 05-11ний өдрүүдэд амжилттай оролцлоо.

Алслагдсан сумдын иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлэх ажил арга хэмжээний дагуу Багануур дүүрэг, Баяндэлгэр, Баянжаргалан, Эрдэнэ, Архуст, Баян, Баянцагаан Мөнгөнморьт зэрэг сумдаар 7 хоног аялан тоглолтоор үйлчиллээ. Үүнд:

Их зохиолч Д.Нацагдоржийн цомнол, Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Б. Дамдинсүрэнгийн хөгжим

- “Учиртай гурван толгой” дуурь

- Панфилова Рыжковагийн зохиол “Шившлэгтэй зургийн нууц” хүүхдийн жүжиг

- Г. Мишээлийн зохиол “Сарьсан багваахайн домог” хүүхэддэйн жүжиг

-Төрийн соёрхолт, УГЗ Ш.Гүрбазарын зохиол “Шар гэгээ” драмын жүжгийг тус тус толилууллаа.

Аймгийн нийтийн номын сан:

Очир эрдэнийн эрхшээлт контент нэвтрүүлэг-2:

Аугаа их нэрт зохиолч, Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн амьдрал уран бүтээл туурвилыг санан дурсаж, түүний утга агуулгын талаар контент нэвтрүүлгийг Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Ш.Цэрэндоо Д.Нацагдоржийн болон Монголын Зохиолчдын эвлэлийн нэрэмжит шагналт, Хүүхдийн зохиолч О.Сундуй, Д.Нацагдоржийн болон Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт, Ардын боловсролын тэргүүний ажилтан Ш.Бадарч нарыг оролцуулан хийлээ.

Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 116 жилийн ойг тохиолдуулан Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, зохиолчдын номын үзэсгэлэн гаргаж 14 зохиолчийн, 84 ширхэг номоор 95 хүнд хүрч үйлчиллээ.

“Оюунд гэрэл нэмье” бичил төслийн хүрээнд “Оюунлаг эмэгтэйчүүд групп”-ээс групп чатдаа өдөр бүр цахим ном, сургамжит өгүүллэг, шинэ номын каталог, сонсдог номуудыг оруулж мөн шинэ номын танилцуулга, электрон каталогийн түүвэр зэргийг ээжүүддээ хүргэж

байна. Тухайн сард 11 ээжид үйлчилгээ үзүүлжээ. Тогтмол хэвлэлийн танхимаас “Анхдугаар таван жил” сонингийн дугааруудыг цувралаар цахимаар хүргэлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн оролцоог дэмжих, тэдэнд номын сангийн үйлчилгээг хүргэх зорилгоор сонсдог номын үйлчилгээ үзүүлж, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж, дархлааг дэмжих зорилгоор Баянхошуу 3-р баг, Баруун Зуунмод 6-р баг, Нацагдорж 5-р багийн тусгай хэрэгцээт нийт 30 хүүхдүүдийн эцэг эхчүүдийн төлөөлөлд дархлаа дэмжих бүтээгдэхүүн, 30 ширхэг үлгэрийн болоод буддаг ном бэлэглэлээ.

Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн алслагдсан багийн иргэдэд үйлчлэх тоо, чанарыг ахиулах зорилгоор “Зөөврийн номын сан”-ийн үйлчилгээг нийт 167 иргэнд 142 номоор 5 сумын 12 байгууллагад үйлчлээд байна.

2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд одонтын ногоон байгууламжийн хашаанд 21 ширхэг гүйлс модыг тарилаа

Аймгийн музей:

Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/484 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Музейгээс 3-4 хүний бүрэлдэхүүнтэй баг сум орон нутагт тооллогын ажлыг зохион байгуулж байна. ТСҮХД-ын улсын тооллогын нэгдсэн цахим www.richtmongoluv.mn программын шивэлт 42,1%-ийн гүйцэтгэлтэй байна.

Монголын Үндэсний музей, Өмнөговь аймгийн музей хамтран зохион байгуулж буй “Музейн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах нь” сургалт 2022 оны 10 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулагдаж музейн захирал болон музейн 3 албан хаагч хамрагдлаа.

2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд одонт хөтөлд 6 ширхэг голт бор тарьсан.

ТАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Хяналт шалгалтын хүрээнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтын газраас хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж “Нийгмийн даатгалын тухай хууль”-д заасан болзлоор малчин, хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгохдоо хуурамч материал бүрдүүлсэн байж болзошгүй 14 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг шалгуулахаар Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн. Шалгах ажиллагаанд хяналт тавиулахаар Прокурорын газарт хүсэлт гаргасан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийхэд: 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын сан болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 121 мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв байршуулсан байна.

Нийгмийн даатгалын сан болон үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлтэй холбоотой мэдээ, мэдээлэл, тайланг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн дүнгээс харахад мэдээ, тайланг 76,4 хувьтай хугацаанд нь байршуулж мэдээлсэн байна.

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д зааснаар иргэний нэхэмжлэлтэй шүүх хуралд хяналт шалгалт, дотоод аудитын тасгаас 3 удаа нийгмийн даатгалын хэлтсийг төлөөлж гуравдагч этгээдийн үүргээр татагдан оролцсон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хүрээнд:

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурал 4 удаа хуралдаж, нийт 230 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 187 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 145 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 8 иргэнийг цуцалсан байна. Эрдэнэ суманд 10 дугаар сарын 14-ний өдөр нүүдлийн хурлыг зохион байгуулж ажилласан.

Нийгмийн даатгалын сангийн чиглэлээр:

Жирэмсэн амаржсаны тэтгэмж 666 даатгуулагчид 1,126.1 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 1046 даатгуулагчид 139.8 сая, ажилгүйдлийн тэтгэмж 290 даатгуулагчид 660.5 сая төгрөг тус тус олгосон байна.

Хаан банк болон Төрийн банкаар дамжуулан 17347 тэтгэвэр авагчдад 8,3 тэрбум төгрөгийн тэтгэврийг аймгийн хэмжээнд олгон ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын ын чиглэлээр

ЭМДЕГ-тай гэрээт 73 Эрүүл мэндийн байгууллагуудаас 09 дүгээр сарын 01-ээс 09 сарын 31-ний өдөр хүртэл эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн 81 байгууллагын гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналт хийж, 274 иргэний 85,1 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн. Зуунмод

сумын ИТХ-ын төлөөлөгчдийн өдөрлөгт оролцон, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр 100 гаруй иргэдэд мэдээлэл, сурталчилгаа хийсэн.

ЗУРГАА. БИЕЙН ТАМИР СПОРТЫН ТАЛААР

МУ-ын ЗГ-ын 96-р тогтоолоор хос бичигтэн болох зорилтын хүрээнд ажилчин албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулах ажлыг эрчимжүүлэн Албан бус боловсролын төвтэй хамтран сургалтад хамрагдаж байна.

Өвлийн спортыг хөгжүүлэх зорилгоор Монголын цанын холбооноос Хэнтий аймгийн Биндэр суманд зохион байгуулсан Монгол-Швейцарын хамтарсан өвлийн спортыг хөгжүүлэх үндэсний төвийн дэд дарга, техникийн ажилтан нарын чөлөөт уулзалтад Биеийн тамир спортын газрын дарга, дасгалжуулагч нар хамрагдлаа.

Уулзалтад: Увс, Булган, Төв, Орхон, Дархан, Завхан, Хөвсгөл, Хэнтий, Сэлэнгэ Архангай, Өвөрхангай, Дорнод, УБ хотоос нийт 30 гаруй дасгалжуулагч оролцож аймгуудад хуваарилагдсан цанын хэрэглэл материалыг хүлээн авлаа.

Зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд:

Монгол Улсын хөдөлмөрийн баатар, МУ-ын гавьяат тамирчин, олимпын наадмын анхны мөнгөн медальт, ДДДДД аварга Ж.Мөнхбат агсны нэрэмжит үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах 48 дах удаагийн барилдааныг 2022.10.12-13-нд зохион байгуулан 15 сумын 18 байгууллагын 123 бөхчүүд зодоглон аваргуудаа шалгарууллаа.

Монгол Улсын ХХ зууны манлай дасгалжуулагч Г. Сумьяасүрэн агсны нэрэмжит “Гоолын баяр-2022” тэмцээн 2022.09 дүгээр сарын 10-аас 10 дугаар сарын 09-ний хооронд зохион байгуулагдан 28 багийн 230 тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. БТС-ын байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн нэрэмжит “ТӨВ МАСТЕР КАП-2022” гранд гольфийн нээлттэй тэмцээнийг 2022.10.22-ны өдөр Зуунмод суманд зохион байгуулж 10 байгууллагын эрэгтэй 45, эмэгтэй 63 нийт 108 тамирчин 60 хүртэлх нас, 60-69 нас, 70-аас дээш насны ангилалд өрсөлдөн аваргуудаа шалгарууллаа.

Оролцсон уралдаан тэмцээний хүрээнд:

2022.10.13-17-нд Армени улсын Ереван хотноо болсон Самбо бөхийн 2022 оны өсвөр үе, залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өсвөрийн хөвгүүдийн 64 кг жинд барилдсан Б.Батдаваа алтан медаль, 16 хүртэлх насны хөвгүүдийн 71 кг жинд С.Заяа, 49 кг-ын жинд Б.Чинхүслэн нар хүрэл медалийн төлөө барилдан шагналт 5-р байранд шалгарлаа.

Төв аймгийн Аргалант сумын харьяат Төв-Хан-Алтай клубийн шатарчин Э.Хүслэн Индонезийн Бали аралд зохион байгуулагдсан Өсвөрийн Азийн аварга шалгаруулах шатрын тэмцээнд үндсэн төрөлд 9 өргөөс 7.5 оноо авч 1-р байр алтан медаль хүртэж Олон улсын шатрын холбооны мастер /WFM/ цолны болзол хангалаа.

МЖ клубийн нэрэмжит чөлөөт бөхийн тэмцээн 10 дугаар сарын 20-21-нд Сонгино хайрхан дүүргийн спорт зааланд болж 30 байгууллагын 630 гаруй тамирчид өрсөлдсөнөөс Төв аймгийн баг 1 алт, 3 мөнгө, 6 хүрэл нийт 10 медаль хүртэж багийн дүнгээр тэргүүн байр эзлэн алтан цомын эзэд боллоо.

Баянхонгор аймагт зохиогдсон үндэсний бөхийн 2022 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд 2022.10.22-23-ны өдрүүдэд болж Төв аймгаас оролцсон баг тамирчид 1 мөнгөн медаль хүртэж Н.Батбилгүүн "Уран гараа дэвээт бөх"-ийн шагналыг авлаа.

Нийтийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээнд 461 хүнийг хамруулан улс, олон улсын тэмцээнээс 3 алт, 4 мөнгө, 6 хүрэл медаль хүртлээ.

НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:

2022 оны II ээлжийн цэрэг татлагыг 18 суманд 09 дүгээр сарын 29-өөс 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд батлагдсан хуваарь, маршрутын дагуу ажиллаж, нэгдсэн татлагыг 10 дугаар сарын 17,18-ны өдөр аймгийн Биеийн тамир, спортын газрын байранд зохион явуулж, 2022 оны 10 дугаар сарын 18,19, 24-ний өдрүүдэд Зэвсэгт хүчин, Хилийн болон дотоодын цэргийн төв дамжинд тэнцсэн цэргүүдийг хүлээлгэн өгч, Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн хяналтын тоог 87,9 хувь биелүүлэн ажиллалаа.

2021 оны II ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдаж Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги нэгтгэлүүдэд албаа хаагаад бэлтгэлээр халагдсан дайчдыг 2022 оны 10 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд аймгийн “Мөнх алдар”-ын талбайд хүндэтгэн хүлээн авах арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд Төв аймгийн ЗДТГ-ын дарга бөгөөд Цэрэг татлагын товчооны дарга М.Отгонбат, Цэргийн штабын дарга дэд хурандаа Т.Төмөрчөдөр, Цэргийн штабын офицерууд, сумын ЗДТГ-ын дарга нар, багийн Засаг дарга нар болон эцэг, эх, ар гэрийн төлөөлөл оролцсон.

Цэргийн алба нэр төртэй хаагаад ирсэн залууст аймаг, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газрын алба хаагчид төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд ажиллах ажлын санал тавьж сум орон нутагтаа үйл ажиллагаа явуулдаг Угтаалцайдам сумын “Уушиг хайрхан”ХХК-ны ажиллах эрхийн бичиг, Заамар сумын Засаг даргын Тамгын даргын талархал, мөнгөн урамшуулал гардуулж өгсөнд талархаж байна.

Цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн буюу 26-27 настай иргэдийн судалгааг гаргаж мэдэгдэх хуудас тараан, гэрээ хийсэн иргэд мөнгөн төлбөрөө ирэх цэрэг татлагын өмнө тушаасан байхаар хамтарсан гэрээ байгуулан ажиллалаа. Мөн мөнгөн төлбөр төлөх насны дээд хязгаарт хүрсэн ч ар гэрийн гачигдал болон эрүүл мэндийн шалтгаанаар тэнцэхгүй иргэдийн 15 өргөдөл холбогдох бичиг баримтыг хүлээн авч шийдвэрлэхэд бэлэн болоод байна.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР